10.22 Agricultural areas.....	220
10.23 Sown areas, by regions, aimags and the capital, by type of plants.....	221
10.24 Total crops, by type of plants.....	226
10.25 Yields of staple agricultural crops per hectar, by type of plants.....	226
10.26 Total crops, by regions, aimags and the capital, by type of plants.....	227
10.27 Yields of cereals, potatoes per hectar, by regions, aimags and the capital.....	230
10.28 Gross hay harvest and laying-in of fodder, by type.....	231
10.29 Fodder, by regions, aimags and the capital, in terms of fodder unit.....	231
10.30 Fodder, by regions, aimags and the capital, by type.....	232
SECTION 11. INDUSTRY.....	236
11.1 Gross industrial output, by divisions and subdivisions, at current prices.....	237
11.2 Composition of gross industrial output, by divisions and subdivisions.....	238
11.3 Gross industrial output, by employment size class, at current prices.....	239
11.4 Gross industrial output, by division, at constant prices of 2005.....	240
11.5 Sales of industrial products, by regions, aimags and the capital, at current prices.....	241
11.6 Industrial labour productivity, by divisions, at current prices.....	242
11.7 Production of major commodities.....	243
11.8 Some industrial production per capita.....	245
11.9 Balance of electricity.....	245
11.10 Balance of coal.....	247
11.11 Balance of thermal energy.....	247
SECTION 12. TRANSPORTATION.....	251
12.1 Main indicators of transportation, by types.....	252
12.2 Number of vehicles, by type.....	252
12.3 Number of vehicles passed technical inspection, by region, aimags and the capital.....	253
12.4 Main indicators of railway transportation.....	254
12.5 Main indicators of road transportation.....	254
12.6 Main indicators of civil air transportation.....	255
12.7 Improved auto road, km.....	255
SECTION 13. TELECOMMUNICATION.....	257
13.1 Main indicators of telecommunication sector.....	258
13.2 Telecommunication and postal service indicators, by type.....	258
13.3 Number of telephone lines, by regions, aimags and the capital city.....	259
SECTION 14. INTERNATIONAL MERCHANDISE TRADE STATISTICS.....	262
14.1 Total turnover, by countries, at current prices.....	264
14.2 Exports, by countries, at current prices.....	265
14.3 Imports, by countries, at current prices.....	266
14.4 Exports and imports, by continent, by region, at current prices.....	267
14.5 Main export commodities.....	268
14.6 Main import commodities.....	269

14.7	Composition of export, by groups of commodities.....	272
14.8	Composition of import, by groups of commodities	273
14.9	Price indexes of foreign trade, by main groups of commodities, percent.....	274
14.10	Indexes of foreign trade and terms of trade, percent	274
14.11	Volume indexes of foreign trade, by main groups of commodities, percent.....	275
14.12	Export and import , by some groups of commodities, by standart classification of international trade	276
SECTION 15. BALANCE OF PAYMENTS		279
15.1	Balance of payments	280
SECTION 16. TRADE		282
16.1	Total sales and output of wholesale and retail trade sector, at current prices	283
16.2	Population per commercial unit, by region, aimags and the capital, at the end of the year.....	283
16.3	Total output of hotel and restaurant sector, at current prices	284
16.4	Total number of employees of hotel and restaurant sector, at the end of the year.....	284
SECTION 17. HOUSING, PUBLIC SERVICES AND AMENITIES.....		286
17.1	Housing, at the end of year	287
17.2	Some statistics of facilities for public services and amenities, by region, aimags and the capital city.....	288
SECTION 18. TOURISM.....		291
18.1	Inbound and outbound passengers, by immigration posts.....	292
18.2	Outbound domestic passengers, by immigration posts, purpose of visit, 2011	292
18.3	Inbound passengers, by purpose of visit, as of 2011.....	293
18.4	Inbound tourists, by country	293
18.5	Foreign passengers crossed the border of Mongolia, by country	294
18.6	Composition of foreign passengers, by purpose of visit and geographical regions, 2011	294
18.7	Enterprises in the tourism sector and their employees end of the year	294
SECTION 29. HOUSEHOLD INCOME, EXPENDITURE AND MINIMUM SUBSISTENCE LEVEL OF POPULATION		296
19.1	Monthly average income per household, by urban and rural, at current prices.....	297
19.2	Composition of monthly average income per household.....	297
19.3	Monthly average expenditure per household, by urban and rural, at current prices	298
19.4	Composition of monthly average expenditure per household.....	298
19.5	Monthly average per capita consumption of some foodstuff, by adult equivalent, urban and rural.....	300
19.6	Composition of daily foodstuff consumption and calories per person, by adult equivalent, urban and rural.....	300
19.7	Poverty measures, by urban and rural, region and location.....	301
19.8	Minimum subsistence level of population, per capita per month, by region.....	301
19.9	Monthly average per capita consumption, by main categories of consumption, urban and rural, 2011	302
19.10	Monthly average per capita consumption, by main categories of consumption, poverty status, urban and rural, 2011	302

19.11 Monthly average per capita consumption, by household deciles, urban and rural, 2011	303
19.12 Consumption shares, by household quintiles, urban and rural, 2011	303
19.13 Investments for the improvement of the health, education and infrastructure within the framework of "Sustainable livelihoods project-ii", by regions, aimags and the capital	304
19.14 Investments for the pastoral risk management in the framework of "Sustainable livelihoods project-ii", by regions and aimags	307
19.15 Loans provided by the micro finance development fund, with in framework of "Sustainable livelihoods project-ii", by regions, aimags and the capital	313

**SECTION 20. EDUCATION, SCIENCE, CULTURE AND ARTS,
MONASTERIES,TEMPLES AND CHURCHES 315**

20.1. Educational institutions, as the beginning of academic year.....	316
20.2. Pupils and students in all levels of educational institutions, as the beginning of academic year.....	316
20.3 Graduates of all level educational institutions, as the beginning of academic years	317
20.4 Teachers of all level educational institutions, as the beginning of academic years.....	317
20.5 Some indicators of general educational schools	318
20.6 Students and graduates of domestic universities, institutes and colleges by professional areas.....	319
20.7 General educational schools, by regions, aimags and the capital, at the beginning of academic years	320
20.8 Full-time pupils of general educational schools, by regions, aimags and the capital, at the beginning of academic years.....	321
20.9 Pupil-teacher ratio for general educational schools, by regions, aimags and the capital, at the beginning of academic years	322
20.10 Teachers in general educational schools, by regions, aimags and the capital, at the beginning of academic years	323
20.11 Full-time graduates of the general educational schools, by regions, aimags and the capital	324
20.12 Pupils enrolled in 1st grade of general educational schools, by regions, aimags and the capital, at the beginning of academic years	325
20.13 Pupils of general educational school who made request to live in dormitories and living in dormitores, by regions, aimags and the capital	326
20.14 Herder household's children studying in general educational schools and living in dormitories, by regions, aimags and the capital, at the academic year 2011/2012	327
20.15 Pupils with disabilities studying in general educational schools and living in dormitories, by regions, aimags and the capital, at the academic year 2011/2012.....	328
20.16 Pre-school institutions and children, as the beginning of academic years.....	329
20.17 Pupils and students in all levels of educational institutions, per 1000 in habitants.....	329
20.18 Gross enrolment ratio (ger), by percent, by regions, aimags and the capital, at the academic year 2011/2012	330
20.19 Pre-school institutions and teachers, by regions, aimags and the capital, as the beginning of academic years	331
20.20 Children in pre-school institutions, by regions, aimags and the capital, as the beginning of academic years	332
20.21 Expenditure on educational sector, at current prices	333
20.22 Main indicators of science sector	333
20.23 Full-time employees with scientific degrees and titles, at the end of the year	333
20.24 Research works funded by general government budget.....	334
20.25 Public libraries, at the end of the year	334

20.26 Number of public libraries , by regions, aimags and the capital	335
20.27 Number of employees of art and culture institutions by types, at the end of the year.....	335
20.28 Number of seats of public libraries, by regions, aimags and the capital	336
20.29 Number of permanent readers of public library, by regions, aimags and the capital	337
20.30 Performances of professional art organizations, by regions, aimags and the capital	338
20.31 Spectators of professional art organizations, by regions, aimags and the capital	339
20.32 Museum exhibits , by regions, aimags and the capital	340
20.33 Visitors of museum , by regions, aimags and the capital	341
20.34 Number of cultural centers, by regions, aimags and the capital	342
20.35 Seats of cultural centers, by regions, aimags and the capital	343
20.36 Temples and churches, by religion types, region, aimags and the capital, at the end of the year	344
20.37 Employees of temples and churches, by religion types, region, aimags and the capital, at the end of the year	345
20.38 Monks and missionaries, by religion types, region, aimags and the capital, at the end of the year ...	346
20.39 Students studying in religious schools and colleges , by religion type, region, aimags and the capital, at the end of the year	347
20.40 Children studying in religious conceptions at home, by religion types, region, aimags and the capital, at the end of the year	348
20.41 Students studying in religious school and colleges , and children studying at home, by age group, at the end of the year.....	349

**SECTION 21. PUBLIC HEALTH OF POPULATION,
"CHILD DEVELOPMENT-2010" SURVEY (MICS)352**

21.1. Health institutions	354
21.2. Hospital beds, by type, at the end of the year	354
21.3. Employees of health organizations, by specialization categories, at the end of the year.....	355
21.4. Physicians, by region, aimags and the capital	356
21.5. Pharmacists, by region, aimags and the capital.....	357
21.6. Mid level medical personnel, by professions	358
21.7. Persons per physician, by regions, aimags and the capital.....	358
21.8. Persons per nurse, by regions, aimags and the capital.....	359
21.9. Inpatients, by regions, aimags and the capital	360
21.10. Infectious diseases, by classification of diseases, by region, aimags and the capital	361
21.11. Live births, by sex, weight, at birth, by region, aimags and the capital, at the end of the year 2011 ..	362
21.12. Deaths, by classification of the leading causes, by sex, at the end of the year	364
21.13. Infant mortality, per 1000 live births, by regions, aimags and the capital	365
21.14. Maternal deaths, by regions, aimags and the capital.....	366
21.15. Abortions, by regions, aimags and the capital.....	367
20.16. Expenditure of health sectors, at current prices	367
21.17. Inpatients, per 10 000 population, 10 leading causes of morbidity.....	368
21.18. Prevalence and deaths of malignant neoplasms, per 10 000 population, by type of malignant neoplasms	368
21.19. Prevalence of malignant neoplasms, per 10000 population, by age group	369
21.20. Prevalence and deaths of malignant neoplasms, per 10000 population, by aimags and the capital, at the end of the year 2011	370

21.21 Percentage of pregnant women who attended to anc by regions, aimags and the capital, at the end of the year 2011	371
21.22. Immunization coverage for infants, by types of immunization, at the end of the year 2011	372
21.23. Some indicators of physical culture and sport , by regions, aimags and the capital, at the end of the year 2011	373
21.24 Athlets, coaches and referees with title by regions, aimags and the capital, at the end of the year 2011	374
"Child development-2010" survey (mics)	375
21.25 Child malnourishment, by sex, area, location, region, age group and mother's educational level, in 2000, 2005 and 2010	375
21.26 Knowledge and use of contraception among women aged 15-49 years, by area, location, region, age group and educational level, in 2010	376
21.27. Knowledge about hiv/aids transmission among women aged 15-49 years, by area, location, region, age group and educational level, in 2000, 2005 and 2010	377
21.28. Knowledge of mother-to-child hiv transmission among women aged 15-49 years, by area, location, region, age group and educational level, in 2000, 2005 and 2010	378
21.29. Knowledge of a facility for hiv testing among women aged 15-49 years, by area, location, region, age group and educational level, in 2000, 2005 and 2010	379
21.30 Exposure to mass media among women aged 15-49 years, by area, location, region, age group and educational level in 2010	380
21.31. Exposure to mass media among men aged 15-54 years, by area, location, region, age group and educational level in 2010	381
21.32. Use of computer and internet, by sex, area, location, region, age group and educational level in 2010	382
21.33 Perception of a better life among young people aged 15-24 years, by sex, area, location, region, age group and educational level in 2010	383
21.34. Use of tobacco and alcohol, by sex, area, location, region, age group and educational level in 2010	384
SECTION 22. SOCIAL INSURANCE, WELFARE.....	386
22.1. Revenue and expenditure of social welfare services, by types	387
22.2. Beneficiaries of social welfare pensions, allowances, benefits and concessions, by types	388
22.3. Number of pensionaries , who receipt pensions from the social insurance fund, by type of pension	389
22.4. Revenue of social insurance fund and number of insurers	389
SECTION 23. CRIME.....	391
23.1. Number of committed offences, by classification and types of offences	392
23.2. Number of committed offences, by regions, aimags and the capital	393
23.3. Number of crimes against human life and health, by regions, aimags and the capital	394
23.4. Number of crimes against children, family and social morals, by regions, aimags and the capital.....	395
23.5. Number of crimes against the right of ownership, by regions, aimags and the capital	396
23.6. Number of theft of cattle, by regions, aimags and the capital	397
23.7. Number of crimes against public security, by regions, aimags and the capital	398
23.8. Number of crimes against the rules of safety of traffic and use of motor vehicles, by regions, aimags and the capital.....	399

23.9. Number of economic crimes, by regions, aimags and the capital	400
23.10. Number of offences per 10000 population aged 18 and above, by regions, aimags and the capital	401
23.11. Number of offenders (suspects and defendants), by regions, aimags and the capital	402
23.12. Crime caused damage	403
23.13. Number of victims	403
23.14. Number of victims, by social status	403
23.15. Number of victims, by age groups	403
23.16. Number of convicted persons by court, by regions, aimags and the capital	404
23.17. Number of convicted persons by court	405
23.18. Number of convicted persons by court, by education level	405
23.19. Number of convicted persons by court, by age groups	405
SECTION 24. ENVIRONMENT	407
24.1 Unified land territory of Mongolia, by main types	408
24.2 Forest fund area, by regions, aimags and the capital city, in 2011	408
24.3 Annual average temperature (co), by aimag centers and the capital	409
24.4 Number of rainy days and precipitation, by aimag centers and the capital	410
24.5 Multiyear average of climate, by aimag centers and the capital	411
24.6 Forest fires, duplicated number, region, aimags and the capital	412
24.7 Forest harvest volume, by region, aimags and the capital	413
24.8 Capital investment for protection and rehabilitation of natural resources	414
24.9 Maximum limit of wild animal hunting for domestic purposes, in 2012, by region, aimags and the capital, by hunting animals	414
24.10 Land degradation	415
24.11 Surface water, by region, aimags and the capital, census by years	416
24.12 Disasters and damages	417
24.13 Annual average concentration of pollutants in air, by aimag centers and the capital, in 2011	417
24.14 Daily average concentration of pollutants in air of Ulaanbaatar,	418
24.15 Maximum allowable concentration of air quality standard	418
SECTION 25. PRODUCTIVITY	420
25.1 Total productivity, by divisions, at current prices	421
25.2 Total factor productivity, by divisions, at current prices	421
25.3 Labor productivity, by divisions, at 2005 constant prices	422
25.4 Fixed capital productivity, by divisions, at current prices	422
25.5 Main raw materials productivity, by divisions, at current prices	423
25.6 Electricity productivity, by divisions, at current prices	423
SECTION 26. BUSINESS REGISTER	425
26.1 Number of establishments in the business register, by regions, aimags and the capital, at the end of year	426
26.2 Number of establishments, by divisions of economic activities, at the end of year	427
26.3 Number of establishments, by employment size class, at the end of the year	428
26.4 Number of establishments, by legal status, at the end of the year	428

26.5	Number of active establishments, by regions, aimags and the capital, at the end of year	429
26.6	Number of active establishments, by divisions of economic activities, at the end of year	430
26.7	Number of active establishments, by employment size class, at the end of year	430
26.8	Number of registered establishments in the capital city, by districts, at the end of year	431
26.9	Number of registered establishments in the capital city, by employment size class, at the end of year	431
26.10	Number of cooperatives in the business register, the amount of stakeholder's capital, number of members, by regions, aimags and the capital	432
26.11	Number of cooperatives, the amount of stakeholder's capital, number of members, by divisions of economic activities	433
SECTION 27. HUMAN DEVELOPMENT INDEX (HDI).....		436
27.1	Human development index, by regions, aimags and the capital	438
27.2	Gender development index, by regions, aimags and the capital	439
27.3	Gender empowerment measure, by region, aimags and the capital	440
SECTION 28. MILLENNIUM DEVELOPMENT GOALS INDICATORS.....		442
28.1	Millennium development goals indicators.....	443
SECTION 29. WORLD DEVELOPMENT INDICATORS		449
29.1	Size of economy, as of 2009	450
29.2	Integration with the global economy, % of GDP	454
29.3	Distribution of net aid by development assistance committee members, 2009, by regions	455
29.4	Official development aid dependency, by some selected countries of the regions	456
29.5	Structure of output, by some selected countries of the regions	457
29.6	Structure of final demand, by some selected countries of the regions	458
29.7	International trade, selected countries of the regions	459
29.8	Implementation of millennium development goals, by some selected countries of the regions	460

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ХҮН АМ

Монгол Улсын хүн амын тоо 2011 оны жилийн эцсийн байдлаар 2811.6 мянга болж, өмнөх оныхоос 50.6 мянган хүн буюу 1.7 хувиар өслөө. Хүн амын 48.5 хувь нь эрэгтэйчүүд, 51.5 хувь нь эмэгтэйчүүд юм. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 94 байна.

Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөний урсгал их байгаа нь нийслэл хотын хүн ам хурдтай өсөх нөхцөл болж байна. Нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүн амын тоо 2011 оны байдлаар Улаанбаатар хотод 274 болж 2008 оныхоос 30 хүн (12.1 хувь), 2009 оныхоос 19 хүн (7.5 хувь), 2010 оныхоос 9 хүн (3.4 хувь)-ээр тус тус нэмэгджээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 66.2 хувь буюу 1789.2 мянган хүн хот, тосгонд амьдарч байгаагийн дотор, ялангуяа Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгийн хүн амын талаас илүү хувь нь хот, тосгонд оршин сууж байна. Харин Архангай, Булган, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв аймгуудад хүн амын 70-аас дээш хувь нь хөдөөд амьдарч байна.

Улсын хэмжээнд 2011 оны байдлаар 759.9 мянган өрх, түүний 63.6 хувь нь хотод, 36.4 хувь нь хөдөөд байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.7 хүн ногдож байна.

Төрөлтийн түвшин 2006-2009 онд нэмэгдэж, 1000 хүнд ногдох төрөлт 2009 онд 25.7 хүрч байснаа 2010 онд 23.1 болж буурсан ч 2011 онд 25.1 болж, өмнөх оныхоос 2.0 пунктээр өслөө. Төрсөн хүүхдийн тоо 2011 онд 69.9 мянгад хүрч, 2008 оныхоос 9.5 хувь, 2009 оныхоос 1.0 хувь, 2010 оныхоос 10.4 хувиар өссөн байна. Манай улсын хүн амын төрөлтийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 104 хөвгүүн ногдож байна. Төрөлтийн нийлбэр коэффициент 2008 онд 2.6, 2009 онд 2.8, 2010 онд 2.4 байсан бол 2011 онд 2.6 болж нэмэгдлээ.

Хүн амын нас баралтын түвшин 2008 оноос аажмаар өсөх хандлагатай байгаа бөгөөд 2011 онд 1000 хүнд ногдох нас баралт 6.9-д хүрч, өмнөх оныхоос 0.2 пунктээр өслөө. Аймаг, нийслэлийн түвшинд 1000 хүнд ногдох нас баралт 2011 оны байдлаар Архангай, Баянхонгор, Дундговь, Завхан, Төв, Сүхбаатар аймгуудад хамгийн их, Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотод хамгийн бага байна. Нэг нас хүрээгүй хүүхдийн эндэгдэл буюу нялхасын эндэгдлийн түвшин 2008-2010 онд өсч, 2011 онд 16.5 болж, өмнөх оныхоос 3.7 пунктээр буурав.

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2011 онд улсын хэмжээнд 68.32 болж өмнөх оныхоос 0.27 пунктээр нэмэгдсэн бөгөөд 2011 онд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 73.76, эрэгтэйчүүдийнх 64.68 боллоо.

Нийт 11.9 мянган хос 2011 онд гэрлэлтээ бүртгүүлж, 3.2 мянган гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 2.1 мянган хүүхдийг үрчилж авчээ. Гэрлэлт өмнөх оныхоос 27.0 хувиар, гэр бүл цуцлалт 5.5 хувиар өсч, хүүхэд үрчлэлт 15.8 хувиар буурсан байна. Харин 1000 хүнд ногдох гэрлэлт 2010 онд огцом буурч, 12.7-оос 3.4 болсон бол 2011 онд 4.3 болж өмнөх оныхоос 0.9 пунктээр, гэр бүл цуцлалт 2008 оноос аажмаар өсч, 2011 онд 1.2 болж, өмнөх оныхоос 0.1 пунктээр нэмэгдсэн байна.

ХҮН АМ, НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Улсын хэмжээгээр өнчин хүүхдийн тоо 2011 онд 40.8 мянгад хүрч, нийт хүн амын 1.4 хувийг эзэлж байгаа бөгөөд 2008 оныхоос 15.2 хувь, 2009 оныхоос 11.4 хувь, 2010 оныхоос 4.8 хувиар буурав. Нийт өнчин хүүхдийн 4.3 мянга буюу 10.6 хувь нь бүтэн өнчин, 36.5 мянга буюу 89.4 хувь нь хагас өнчин хүүхдүүд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо 2008 оныхоос 14.2 хувь, 2009 оныхоос 8.1 хувь, 2010 оныхоос 7.7 хувиар, хагас өнчин хүүхдийн тоо 2008 оныхоос 15.4 хувь, 2009 оныхоос 11.4 хувь, 2010 оныхоос 4.7 хувиар буурлаа.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2011 онд 81.4 мянга болж, 2008 оныхоос 6.0 хувь, 2009 оныхоос 0.2 хувь, 2010 оныхоос 0.5 хувиар өсөв. Эдгээр эмэгтэйчүүдийн 46.5 мянга буюу 57.1 хувь нь 3 хүртэл ам бүлтэй, 27.6 мянга буюу 33.9 хувь нь 3-5 ам бүлтэй, 7.3 мянга буюу 9.0 хувь нь 6, түүнээс дээш ам бүлтэй өрхийг тэргүүлж байна. Улсын хэмжээнд 2011 оны байдлаар өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 14.5 хувь нь Баруун, 23.8 хувь нь Хангайн, 21.2 хувь нь Төвийн, 10.6 хувь нь Зүүн бүсэд, 29.9 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

16 хүртэлх насны хүүхэдтэй, гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо 2011 онд 38.7 мянга болж, 2008 оныхоос 8.9 хувь, 2009 оныхоос 8.5 хувь, 2010 оныхоос 3.1 хувиар буурлаа. Эдгээр эмэгтэйчүүдийн 23.4 мянга буюу 60.4 хувь нь 3 хүртэлх хүүхэдтэй, 10.9 мянга буюу 28.4 хувь нь 3-5 хүүхэдтэй, 4.3 мянга буюу 11.2 хувь нь 6, түүнээс дээш хүүхэдтэй байна.

Улсын хэмжээнд 16 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 2011 онд 24.1 мянга буюу нийт өрхийн 3.2 хувийг эзэлж байгаа нь 2008 оныхоос 24.4 хувь, 2009 оныхоос 10.8 хувь, 2010 оныхоос 0.3 хувиар буурчээ.

АЖИЛЛАХ ХҮЧ

“Ажиллах хүчний судалгаа (АХС)”-г Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага(ОУХБ)-ын нийтлэг аргачлал, арга зүйн дагуу анх удаа 2002-2003 онд улирлаар явуулснаар хөдөлмөрийн зах зээлийн улирлын нөлөөллийг тооцох боломжтой болсон.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд заасны дагуу Үндэсний статистикийн хороо 2006 оноос хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулж байна.

Хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулж, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт гаргахын тулд ОУХБ-аас гаргасан стандарт ойлголт, тодорхойлолтод нийцүүлэн, өөрийн орны онцлогийг тусгасан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистик үзүүлэлтийг тооцох аргачлал” Үндэсний статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 01/68/94 тоот хамтарсан тушаалаар батлагдан мөрдөгдөж байна.

2011 оны “Ажиллах хүчний судалгаа”-нд улсын хэмжээгээр аймаг, нийслэлийн 12816 өрх хамрагдлаа.

Ажиллах хүчний судалгааны дүнг тархаасан тооцоогоор 2011 онд эдийн засгийн идэвхтэй хүн 1124.7 мянга байгаагаас 1037.7 мянга буюу 92.3 хувь нь ажиллагчид, 87.0 мянга буюу 7.7 хувь нь ажилгүй иргэд байна.

Хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 2011 онд 62.5 хувь болж, өмнөх оныхоос 0.9 пунктээр өсчээ. Ажилгүйдлийн түвшин 2011 онд 7.7 хувьтай байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар ажиллагчдын 33.0 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, 14.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 8.2 хувь нь боловсролын салбарт, 7.3 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт, 6.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧ

Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн мэдээллээр 2011 оны 1 сарын 1-ний байдлаар төрийн албанд 155.7 мянган албан хаагч ажиллаж байгаа нь 2008 оныхоос 11.0 хувь, 2009 оны оныхоос 8.0 хувь, 2010 оныхоос 5.1 хувиар өсчээ.

Төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчдын 2907 буюу 1.9 хувь нь улс төрийн, 15280 буюу 9.8 хувь нь төрийн захиргааны, 28010 буюу 18.0 хувь нь төрийн тусгай, 109482 буюу 70.3 хувь нь төрийн үйлчилгээний албанд ажиллаж байна.

Төрийн захиргааны албанд ажиллаж байгаа хүмүүсийн 103 буюу 0.7 хувь нь тэргүүн түшмэл, 623 буюу 4.1 хувь нь эрхэлсэн түшмэл, 1905 буюу 12.5 хувь нь ахлах түшмэл, 9275 буюу 60.7 хувь нь дэс түшмэл, 3374 буюу 22.0 хувь нь туслах түшмэлийн зэрэг дэвтэй албан хаагчид байна.

ДУНДАЖ ЦАЛИН

ҮСХ нь ажиллагчдын дундаж цалингийн түүвэр судалгааг 2000 оны 4 дүгээр улирлаас эхлэн улирал тутам улсын хэмжээгээр явуулж, дүнг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбар, аж ахуйн нэгж,

Товч танилцуулга |

байгууллагын өмчийн болон хариуцлагын хэлбэрээр, ажиллагчдын хүйс, ажил мэргэжлийн ангиллаар, мөн аймаг, нийслэлээр гаргаж байна. Түүвэр судалгаанд улиралд дунджаар 1020 аж ахуйн нэгж, байгууллагын 151.2 мянган ажиллагчид хамрагдаж байна.

Ажиллагчдын сарын дундаж цалин 2011 онд 424.2 мянган төгрөг болж, 2008 оныхоос 54.7 хувь, 2009 оныхоос 41.2 хувь, 2010 оныхоос 24.2 хувиар өслөө.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар дараах салбарын ажиллагчдын дундаж цалин улсын дундаж цалингаас: төрийн удирдлага, батлан хамгаалах нийгмийн даатгалын салбарынх 10.1 мян.төг, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарынх 63.0 мян.төг, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 308.2 мян.төг, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбарынх 462.7 мянган төгрөгөөр өндөр байна.

Ажил, мэргэжлийн ангиллаар ажиллагчдын сарын дундаж цалин улсын дундаж цалингаас инженер техникийн ажилтных 6.5 мян.төг, мэргэжилтнийх 59.0 мян.төг, машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагчийнх 118.4 мян.төг, хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерийнх 288.2 мянган төгрөгөөр илүү, бусад мэргэжлийн ажиллагчдын сарын дундаж цалингаас харьцангуй өндөр байгаа юм.

Хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын ажиллагчдын сарын дундаж цалин улсын дундаж болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалингаас өндөр байна.

Ажиллагчдын бодит цалин 2011 онд 2005 оныхоос 2.2 дахин, өмнөх оныхоос 13.8 хувиар өссөн байна. Бодит цалингийн өсөлтийг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар 2005 оныхтой харьцуулахад уул уурхай, олборлох аж үйлдвэрт ажиллагчдынх хамгийн өндөр буюу 3.2 дахин өсч, зочид буудал, зоогийн газарт ажиллагчдынх хамгийн бага буюу 35.9 хувиар өссөн байна. Харин өмнөх оныхоос бодит цалингийн өсөлт барилгын салбарт хамгийн өндөр буюу 26.5 хувь, зочид буудал, зоогийн газарт ажиллагчдынх хамгийн бага буюу 2.3 хувь байна.

ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН

“Өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаа”-гаар нэг өрхийн сарын дундаж нийт орлого 2011 онд 573.5 мян.төг болж, өмнөх оныхоос 125.5 мян.төг буюу 28.0 хувиар өссөн байна. Нийт орлогыг бүтцээр нь авч үзвэл мөнгөн орлого 87.9 хувь, бусдаас үнэгүй авсан зүйлийнх 3.9 хувь, хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүнийх 8.2 хувийг эзэлж байна. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого улсын дунджаар 2011 онд 503.9 мян.төг болж, өмнөх оныхоос 116.8 мян.төг буюу 30.2 хувиар өссөний дотор цалин, хөлсний орлого 48.2 мян.төг буюу 24.1 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 47.2 мян.төг буюу 70.4 хувь, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 15.8 мян.төг буюу 19.0 хувь, бусад орлого 5.6 мян.төг буюу 15.2 хувиар нэмэгдсэн байна.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтцийг өмнөх оныхтой харьцуулахад тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 5.0 пунктээр нэмэгдэж, харин цалин, хөлсний орлогынх 1.4 пункт, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогынх 1.3 пункт, бусад орлогынх 0.8 пунктээр буурчээ.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага улсын дунджаар 2011 онд 507.8 мян.төг болж, өмнөх оныхоос 118.5 мян.төг буюу 30.4 хувиар, үүний дотор хүнсний зүйлийнх 23.5 мян.төг буюу 17.8 хувь, хүнсний бус бараа үйлчилгээний мөнгөн зарлага 90.9 мян.төг буюу 37.2 хувь, бусдад өгсөн бэлэг, тусламж 4.1 мян.төг буюу 31.6 хувиар нэмэгдсэн байна.

Өрхийн сарын дундаж зарлагын бүтцийг өмнөх оныхтой харьцуулахад бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагынх 0.4 пункт, хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүнийх 1.1 пунктээр буурч, харин мөнгөн зарлагын эзлэх хувь 1.5 пунктээр өсчээ.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээр 2011 оны ядуурлын хамралтын хүрээ (2010 оныг суурь болгосон) 29.8 хувь, ядуурлын гүнзгийрэлт 7.6 хувь, ядуурлын мэдрэмж 2.8 хувь болов. Ядуурлын хамралтын хүрээг бүс нутгаар авч үзвэл Хангайн бүсэд 38.9 хувь, Зүүн бүсэд 34.3 хувь, Баруун бүсэд 30.2 хувь, Төвийн бүсэд 27.2 хувь байна. Ядуурлын хамралтын хүрээ 2011 онд хөдөөд 35.3 хувь, сумын төвд 30.9 хувь, аймгийн төвд 31.8 хувь, нийслэл хотод 23.5 хувь байна.

Хүн амын хэрэглээний тэгш бус байдал өндөр хэвээр байгаа нь 2011 оны судалгааны дүнгээр харагдлаа. Хүн амын хамгийн чинээлэг хэсгийн 20 хувийн хэрэглээний дундаж хэмжээ нь ядуу хэсгийн 20 хувийнхаас 5.1 дахин өндөр байна. Хотын хүн амын дундаж хэрэглээ улсын дунджаас 8.8 хувиар, хөдөөгийн хүн амын дундаж хэрэглээнээс 20.6 хувиар дээгүүр байна.

БОЛОВСРОЛ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны хүн амын 98.3 хувь нь бичиг үсэгт тайлагдсан байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2011/2012 оны хичээлийн жилд 164.3 мянган хүүхэд хамрагдсан нь 2008/2009 оны хичээлийн жилээс 25.7 хувиар, 2009/2010 оны хичээлийн жилээс 15.7 хувиар, 2010/2011 оны хичээлийн жилээс 4.5 хувиар нэмэгдсэн байна. Хувилбарт сургалтанд 2011/2012 оны хичээлийн жилд 30.9 мянган хүүхэд хамрагдсан нь 2008/2009 оны хичээлийн жилээс 11.9 хувиар, 2009/2010 оны хичээлийн жилээс 5.1 хувиар буурсан байна. Харин 2010/2011 оны хичээлийн жилээс 9.7 хувиар нэмэгдсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн (ЕБС) тоо 2011/2012 оны хичээлийн жилд 752 болж, 2010/2011 оны хичээлийн жилээсхэс 1-ээр өсчээ.

2011/2012 оны хичээлийн жилийнхээс эхэнд бүх шатны сургуульд суралцагчдын тоо 729.6 мянгад хүрч, 2010/2011 оны хичээлийн жилийнхээс 2.4 мянгаар буурчээ.

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоо 2011/2012 оны хичээлийн жилд 505.4 мянга, орой, эчнээ ангид суралцагчдын тоо 2.4 мянга болж, өмнөх оны хичээлийн жилийнхээс өдрөөр суралцагчид 6.8 мянган хүүхэд буюу 1.3 хувиар, орой, эчнээгээр суралцагчид 0.5 мянга буюу 17.2 хувиар буурчээ.

Суурь боловсролын хамран сургалтын (бохир) хувь 2011/2012 оны хичээлийн жилд 94.7 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 0.1 пунктээр, үүнээс бага боловсролынх 98.1 хувь болж, 0.5 пунктээр буурсан бол дунд боловсролын хамран сургалтын хувь 97.0 хувь болж, өмнөх оны хичээлийн жилийнхээс 2.3 пунктээр өссөн байна.

ЕБС-ийн нэгдүгээр ангид 2011/2012 оны хичээлийн жилд 46.7 мянган хүүхэд шинээр элсэв.

2011/2012 оны хичээлийн жилд сургууль завсардсан 6-14 насны 2.7 мянган хүүхэд нь нийт суралцагчдын 0.5 хувийг эзэлж, 2010/2011 оны хичээлийн жилээс 0.3 пунктээр буурсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоо 2011/2012 онд 19.1 болж, 2010/2011 оны хичээлийн жилийн түвшинд байна. ЕБС-ийн багш нарын тоо 2011/2012 оны хичээлийн жилд өмнөх хичээлийн жилээс 134-өөр буюу 0.5 хувиар нэмэгдэж, 26.5 мянга болжээ.

Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж буй оюутны тоо тогтмол өсч, 2011/2012 оны хичээлийн жилд нийт 221.8 мянган оюутан суралцаж байна. Энэ хичээлийн жилд нийт оюутны 64.1 хувь нь төрийн өмчийн, 35.9 хувь нь хувийн хэвшлийн сургуульд суралцаж байна. Үүнээс их сургуульд 105.9 мянган оюутан, дээд сургууль, коллежид 66.5 мянган оюутан, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 48.1 мянган оюутан суралцаж байна.

2010/2011 оны хичээлийн жилд нийт 35.8 мянган оюутан төгссөнөөс 23.4 хувь нь худалдаа, бизнесийн удирдлага, 16.1 хувь нь багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх, 9.9 хувь нь инженерийн, 6.4 хувь нь хууль, эрх зүйн чиглэлийн мэргэжилтэн байна.

ШИНЖЛЭХ УХААН, СОЁЛ УРЛАГ

Шинжлэх ухааны байгууллагад ажиллагчдын тоо 2011 онд 4120 болж, өмнөх оныхоос 75 хүн буюу 1.8 хувь өсчээ. Нийт ажиллагчдын 52.7 хувь нь эмэгтэй, 62.7 хувь нь үндсэн ажиллагчид байна.

Шинжлэх ухааны салбарын нийт зардал 2011 онд 28.7 тэрбум төг болж, өмнөх оныхоос 7.1 тэрбум төг буюу 32.7 хувиар өссөн ба үүнд хөдөө аж ахуйн шинжлэх ухааны зардал 40.3 хувь, техникийн шинжлэх ухааных 36.7 хувь, байгалийн шинжлэх ухааных 28.2 хувь, анагаах ухааных 25.6 хувь, нийгмийн шинжлэх

Товч танилцуулга |

ухааных 22.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Шинжлэх ухааны байгууллагуудын 2011 оны нийт зардлын 27.5 хувь нь байгалийн, 26.6 хувь нь техникийн, 17.3 хувь нь нийгмийн ухааны, 14.3 хувь нь хөдөө аж ахуйн, 8.1 хувь нь анагаах ухааны салбарт, 6.2 хувь нь их дээд сургуульд ногдож байна.

Улсын төсвөөс санхүүжүүлсэн эрдэм шинжилгээний ажлын зардал 2011 онд 16.7 тэрбум төг болж, өмнөх оныхоос 25.0 хувиар өсч, үүнд шинжлэх ухаан, технологийн төслийн зардал 41.8 хувиар, зэхэц ажлын зардал 21.0 хувиар, онолын суурь судалгааны зардал 7.3 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Нийт зардлын 57.3 хувийг шинжлэх ухаан, технологийн төсөлд, 40.5 хувийг онолын суурь судалгаанд, 2.2 хувийг шинжлэх ухаан, технологийн зэхэц ажилд зарцуулсан байна.

Улсын хэмжээнд 2010 онд 373 номын сангаар 297.4 мянган уншигч үйлчлүүлсэн бол 2011 онд 373 номын сангаар 289.6 мянган хүн үйлчлүүлсэн байна. 10000 хүнд ногдох номын тоо 24.2 мянга болж, өмнөх оныхоос 0.5 мянгаар буурчээ.

Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын тоо 2011 онд 5149 болж, 2010 оныхоос 4.1 хувиар, үзэгчдийн тоо 1974.9 мянга болж, өмнөх оныхоос 2.0 хувиар тус тус өсчээ.

Музейн үзмэрийн тоо 2010 онд 236.6 мянга байсан бол 2011 онд 3.2 хувиар өсч 244.3 мянга, үзэгчдийн тоо 416.0 мянга байснаа 2011 онд 517.4 мянга болж 24.4 хувиар өслөө.

Соёлын төвийн тоо 2011 онд өмнөх оныхтой адил буюу 341 байна. Харин суудлын тоо нь 89.1 мянга болж, өмнөх оныхоос 1.2 мянга буюу 1.3 хувиар өсчээ.

Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын тоо 2011 онд 6457 болж, өмнөх оныхоос 224 хүнээр буюу 3.6 хувиар өслөө.

СҮМ ХИЙД

Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулиар иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй болсноор төрөл бүрийн урсгалын сүм хийд олноор байгуулагдаж эхэлсэн. Юуны түрүүнд уламжлалт буддын шашны сүм хийд олноор байгуулагдаж байгаа бөгөөд мөн христийн болон бусад шашны сүм хийд, шашны байгууллагуудын тоо нэмэгдэж байна.

Сүм хийдийн тоо 2011 онд 327 болж 2008 оныхоос 99 буюу 43.4 хувь, 2009 оныхоос 95 буюу 40.9 хувь, 2010 оныхоос 93 буюу 39.7 хувиар өслөө. Нийт сүм хийдийн 43.4 хувийг будда, 49.2 хувийг христ, 5.5 хувийг ислам, 1.9 хувийг бусад шашны сүм хийд эзэлж байна.

Сүм, хийд шашны байгууллагуудад 2011 оны байдлаар нийт 3.5 мян.хүн ажиллаж байгаагаас 1.8 мянга нь хурлын лам байна.

Хурлын лам нарын 151 буюу 8.5 хувь нь Баруун бүсэд, 443 буюу 24.8 хувь нь Хангайн бүсэд, 228 буюу 12.8 хувь нь Төвийн бүсэд, 133 буюу 7.5 хувь нь Зүүн бүсэд, 829 буюу 46.5 хувь нь Улаанбаатарт байна.

Шашны сургууль дацанд суралцагчид 2011 онд 1.4 мянга болж өмнөх оныхоос 12.9 хувиар, гэрээр шашны ном заалгадаг хүүхдийн тоо 4.2 мянга болж 7.5 хувиар тус тус буурлаа.

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн салбарт 2011 онд нийт 41.1 мянган ажиллагчид ажилласан нь өмнөх оныхтой харьцуулахад 3.8 хувиар өссөн байна. Нийт ажиллагчдаас 7.9 мянга нь их эмч, 1.3 мянга нь эм зүйч, 16.5 мянга нь эмнэлгийн тусгай мэргэжилтэн үүнээс 9.4 мянга нь сувилагч, 15.4 мянга нь бусад ажилтан байна.

Арьс, харшил, сүрьеэ, нүд, чих, хамар хоолой, хавдар судлаач, БЗДХ/ДОХ, гоц халдварт, эмгэг судлаач шүүхийн шинжээч болон өрх, сумын эмнэлгийн эмч нарын тоо өмнөх оныхоос буурч, бусад мэргэжлийн эмч нарын тоо өссөн байна. Улсын хэмжээнд их эмчийн тоо 2011 онд 2008 оныхоос 4.7 хувь, 2009 оныхоос 11.2 хувь, 2010 оныхоос 5.9 хувиар өссөн байна. Эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо 2011 онд 2008 оныхоос 2.7 хувь, 2009 оныхоос 4.4 хувь, 2010 оныхоос 4.2 хувиар нэмэгджээ. Нэг их эмчид 2011 онд 1.2 сувилагч ногдож байна. Нэг их эмчид ногдох хүний тоо 2011 онд 337 болж, өмнөх оныхоос 28 хүнээр, нэг сувилагчид ногдох хүний тоо 284 болж, өмнөх оныхоос 14 хүнээр буурсан байна. Хангайн бүсэд дунджаар

нэг их эмчид ногдох хүний тоо хамгийн өндөр буюу 531, төвийн бүсэд хамгийн бага буюу дунджаар 450 байна. Аймгийн түвшинд энэ үзүүлэлт Хөвсгөл аймагт хамгийн их буюу 668, Улаанбаатар хотод хамгийн бага буюу 240 байна.

Эмнэлгийн орны тоо 2011 онд 19.0 мянга болж, 2008 оныхоос 4.9 хувь, 2009 оныхоос 7.0 хувь, 2010 оныхоос 6.4 хувиар өссөн байна. Улсын хэмжээнд эмнэлгийн дундаж ор хоног 8.1 байгаа нь 2008 оныхоос 0.4, 2009 оныхоос 0.2, 2010 оныхоос 0.1 дундаж ор хоногоор буурав.

Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд зүрх, судасны тогтолцооны өвчин (10 000 хүнд 23.5), хавдар (10 000 хүнд 13.2), гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг (10 000 хүнд 11.7), хоол боловсруулах тогтолцооны өвчин (10 000 хүнд 5.7), амьсгалын тогтолцооны өвчин (10 000 хүнд 2.5) орж байна. Хорт хавдраар нас барагчдын дунд элэг (10 000 хүнд 5.3), ходоод (10 000 хүнд 1.7), уушги (10 000 хүнд 1.2), улаан хоолой (10 000 хүнд 1.0), умайн хүзүүний хорт хавдар (10 000 хүнд 0.4) зонхилж байна.

Улсын хэмжээнд 2011 он 26 төрлийн цочмог халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 42.8 мянгад хүрч, 2008 оныхоос 2.2 хувиар буурч, 2009 оныхоос 10.2 хувь, 2010 оныхоос 3.5 хувиар өсчээ. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 34.2 хувийг вирүст хепатитаар, 12.0 хувийг гонококкт халдвараар, 10.0 хувийг тэмбүүгээр, 9.3 хувийг трихомониазаар, 9.3 хувийг сүрьеэгээр, 7.2 хувийг салхин цэцгээр, 5.1 хувийг мөөгөнцөрөөр, 4.9 хувийг цусан суулгаар өвчлөгчид эзэлж байна.

Эрүүл мэндийн салбарын нийт зардал 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 331.3 тэрбум төг болж, 2008 оныхоос 56.5 хувь, 2009 оныхоос 60.5 хувь, 2010 оныхоос 32.4 хувиар нэмэгдсэн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлагад эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2011 онд 6.9 хувь болж, 2008 оныхоос 1.7, 2009 оныхоос 1.9, 2010 оныхоос 1.2 пунктээр тус тус буурлаа.

“ХҮҮХЭД ХӨГЖИЛ-2010” СУДАЛГАА

Манай улсын хувьд хүүхдийн хоол тэжээлийн байдал сайжирч байгаа ч 5 хүртэлх насны хүүхдүүд уураг илчлэгийн дуталд орох байдал үргэлжилсээр байна. Тураалтай хүүхдийн эзлэх хувь 2010 онд 4.7 болж 2005 оныхоос 1.6, 2000 оныхоос 8.0 пунктээр буурав. 2000 онд 4 хүүхэд тутмын 1, 2005 онд 5 хүүхэд тутмын 1, 2010 онд 6 хүүхэд тутмын 1 нь өсөлт хоцролттой болж жил ирэх тусам буурч байна. Харин 5 хүртэлх насны нийт хүүхдийн дунд туранхай хүүхдийн эзлэх хувь 2010 онд 2.3 байгаа нь 2000 оныхоос 2 дахин бага байгаа хэдий ч 2005 оны түвшнээс өөрчлөгдөөгүй байна.

Хосуудын жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл (ЖСАХ)-ийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, улмаар мэдлэгт суурилсан хэрэглээг нэмэгдүүлэх, түүнчлэн ЖСАХ-ийн хэрэгцээг хангах нь гэр бүл төлөвлөлтийн талаарх бодлогын гол зорилго юм. Монгол улсын хэмжээнд 15-49 насны гэрлэсэн / хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 97.4 хувь нь ЖСАХ-ийн талаар мэддэг боловч дөнгөж талаас илүү хувь нь л (54.9 хувь) судалгааны үед жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байжээ. ЖСАХ-ийн хэрэгцээтэй нийт эмэгтэйчүүдийн 71.1 хувийнх нь хэрэгцээ хангагдсан байна.

ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг судлахад судалгаанд хамрагдсан нөхөн үржихүйн насны (15-49 нас) эмэгтэйчүүдийн 92.6 хувь нь ХДХВ, ДОХ-ын талаар сонссон боловч мэдлэг, хандлага, дадлын хувьд тун хангалтгүй байдал ажиглагдаж байна. Эмэгтэйчүүдийн 28.5 хувь нь ХДХВ-ийн халдвар дамжих замыг мэддэг ба ХДХВ-ийн талаарх ташаа ойлголт/ буруу төсөөллийг зөв тодорхойлсон байв. Түүнчлэн эмэгтэйчүүдийн 69.6 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хаана өгөхийг мэддэг боловч ердөө 12.7 хувь нь л судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд уг шинжилгээг өгч, хариугаа авсан байна.

Судалгаанд хамрагдсан 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн 47.6 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа сонин уншдаг, 40.2 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа радио, FM сонсдог, 94.3 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа телевиз үздэг байна. Нийт эмэгтэйчүүдийн 23.4 хувь нь дээрх 3 мэдээллийн хэрэгслээс долоо хоногт наад зах нь нэг удаа мэдээлэл авдаг байна. 25 хүртэлх насны залуу эмэгтэйчүүд бусад насны эмэгтэйчүүдтэй харьцуулахад олон нийтийн мэдээллийн хэрэгслийг илүү хэрэглэдэг байна. Тухайн хүний боловсролын түвшин, амьдарч буй өрхийн байршил, аж байдлын түвшин зэрэг нь мэдээллийн хэрэгслийн хүртээмж, хэрэглээнд мэдэгдэхүйц ялгаа бий болгодог, тэр дундаа хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн хүртээмж, хэрэглээнд илүү их нөлөөлдөг нь ажиглагдлаа.

Монгол Улсын 15-54 насны эрэгтэйчүүдийн 42.2 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа сонин уншдаг, 46.4 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа радио, FM сонсдог, 95.8 хувь нь долоо хоногт наад зах нь 1

Товч танилцуулга |

удаа телевиз үздэг байна. Эрэгтэйчүүдийн 23.6 хувь нь бүх төрлийн мэдээллийн хэрэгслээс долоо хоногт наад зах нь нэг удаа мэдээлэл авдаг байна.

Судалгаанд хамрагдсан 15-49 насны нийт эмэгтэйчүүд, 15-54 насны нийт эрэгтэйчүүдээс компьютер болон интернетийн хэрэглээний талаарх асуултыг асуусан. 15-49 насны эмэгтэйчүүдийн 60.8 хувь нь компьютер, 46.1 хувь нь интернет хэрэглэж үзсэн бөгөөд сүүлийн нэг жилд 51.2 хувь нь компьютер, 39.2 хувь нь интернет хэрэглэсэн байна. Эрэгтэйчүүд компьютер болон интернет хэрэглэх нь эмэгтэйчүүдийнхээ харьцангуй бага байна. Компьютер болон интернетийн хэрэглээ сүүлийн 1 жилийн хугацаанд залуучуудын дунд илүү их өргөн хүрээтэй байна. Компьютер болон интернетийн хэрэглээ нь тухайн хүний боловсролын түвшин, суурьшил болон аж байдлаас ихээхэн хамаарч байна.

Залуучууд амьдралдаа хэр сэтгэл хангалуун байдаг талаар тавьсан асуулгад судалгаанд хамрагдсан 15-24 насны залуучуудын 54.2-54.3 хувь нь судалгаанаас өмнөх нэг жилийн хугацаанд амьдралаа сайжирсан гэж хариулсан нь төдийлөн өндөр үзүүлэлт биш юм. Гэвч залуу эрэгтэйчүүдийн 86.4 хувь, залуу эмэгтэйчүүдийн 92.0 хувь нь ирэх нэг жилд амьдралаа сайжирна гэсэн итгэлтэй байгаа нь Монгол залуучуудын ирээдүйдээ итгэх итгэл дүүрэн байгааг харууллаа.

Судалгаанд хамрагдсан 15-54 насны нийт эрэгтэйчүүдийн 15.9 хувь, 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн 0.6 хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө тамхи татаж үзсэн бол архи, согтууруулах ундааны хувьд, 15-54 насны нийт эрэгтэйчүүдийн 2.7 хувь, 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн 0.2 хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа ууж үзжээ. Тамхины хэрэглээнд хүйсийн ялгаа их байна. Тухайлбал, 30-39 насны (8.2-8.4 хувь), Улаанбаатар хотын (9.7 хувь), дээд боловсролтой (8.3 хувь) эмэгтэйчүүд, 50-54 насны (66.0 хувь), Төвийн бүсийн (59.7 хувь), боловсролгүй (63.7 хувь) эрэгтэйчүүд тамхи их татдаг байна. 15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа ууж үзсэн эрэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд 15-29 насныхны дунд хамгийн өндөр (3.4-5.1 хувь) байгаа нь архи, согтууруулах ундааны хэрэглээ сүүлийн жилүүдэд нэмэгдсэнийг харуулж байна.

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалд 2011 онд нийт 757.2 мян. хүн хамрагдсаны 675.6 мянга буюу 89.2 хувь нь заавал даатгуулагчид, 81.6 мянга буюу 10.8 хувь нь сайн дурын даатгуулагчид байна.

Нийт даатгуулагчдын тоо 2010 оныхоос 99.2 мян. хүнээр буюу 15.1 хувиар нэмэгдсэний дотор заавал даатгуулагчид 81.3 мян.хүнээр буюу 13.7 хувиар, сайн дурын даатгуулагчид 17.9 мян.хүнээр буюу 28.1 хувиар өсчээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2011 онд 755.5 тэрбум төгрөгт хүрч, 2010 оныхоос 132.8 тэрбум төг буюу 21.3 хувиар нэмэгдэв. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо 2011 онд 332.2 мянга болж, 2010 оныхоос 5.3 мянгаар буюу 1.6 хувиар буурлаа.

2011 онд олгосон нийт тэтгэврийн 71.8 хувийг өндөр насны, 15.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 6.7 хувийг тэжээгчээ алдсаны, 6.2 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Нийт тэтгэвэр авагчдын дотор тэжээгчээ алдсаны тэтгэвэрт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрт хамрагдагчдын эзлэх хувь буурч, харин өндөр насны болон цэргийн тэтгэвэрт хамрагдагчдын эзлэх хувь өсөх хандлагатай байна.Тухайлбал, нийт тэтгэвэр авагчдын дунд тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын эзлэх хувь 2008 онд 11.1, 2009 онд 11.3, 2010 онд 10.4, 2011 онд 9.7 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь 2008 онд 20.6, 2009 онд 21.3, 2010 онд 20.7, 2011 онд 20.1 хувь, өндөр насны тэтгэвэр авагчдын эзлэх хувь 2008 онд 64.3, 2009 онд 63.5, 2010 онд 64.8, 2011 онд 66.1 хувь байна.

Нийгмийн халамжийн орлого 2011 онд 134.8 тэрбум төгрөгт хүрч, 2010 оныхоос 1.2 тэрбум төг буюу 0.9 хувиар буурчээ.

Нийгмийн халамжийн зарлага 2011 онд 131.9 тэрбум төгрөг болж, 2010 оныхоос 32.6 тэрбум төгрөг буюу 32.8 хувиар өслөө.

Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 2011 онд 2010 оныхоос 29.0 хувь, тэтгэмж, тусламжийнх 42.2 хувь, үйлчилгээ болон хөнгөлөлтөд зориулсан зардлынх 22.3 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн зардалд тэтгэмж, тусламжийн эзлэх хувь өссөн нь 2011 онд “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай” Монгол улсын хуульд оруулсан нэмэлтээр өмнө нь нэгдүгээр

зэргийн одонг 7 ба түүнээс дээш, хоёрдугаар зэргийн одонг 5 хүүхэдтэй эхэд олгодог байсныг өөрчилж, нэгдүгээр зэргийн одонг 6 ба түүнээс дээш, хоёрдугаар зэргийн одонг 4 хүүхэдтэй эхэд олгох болсноос шалтгаалжээ.

Нийгмийн халамжийн зардалд үйлчилгээ болон хөнгөлөлтөд зориулсан зардлын эзлэх хувь өсөхөд 2010 оны 10-р сараас “Алдарт эх”-ийн одонтой эхчүүдэд жилд нэг удаа олгох тэтгэмжийг 2 дахин нэмэгдүүлсэн нь нөлөөлөв.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжид хамрагдсан хүний тоо 2011 онд 619.6 мянга болж, 2010 оныхоос 111.2 мянган хүн буюу 21.9 хувиар өссөн байна.

Хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 2.8 сая иргэнд 2011 онд 733.1 тэрбум төгрөгийн хувь хишгийг олгосны 96.9 хувь нь 21 мянга, 0.9 хувь нь 70 мянга, 2.2 хувь нь 10 мянган төгрөгийн хувь хишиг авсан байна.

ГЭМТ ХЭРЭГ

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2011 онд 19.2 мянга болж, 2010 оныхоос 628 хэрэг буюу 3.2 хувиар буурчээ. Нийт гэмт хэргийн 7.6 хувь нь Баруун бүсэд, 12.6 хувь нь Хангайн бүсэд, 15.8 хувь нь Төвийн бүсэд, 6.9 хувь нь Зүүн бүсэд, 56.1 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 37.7 хувь, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 33.7 хувь, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 9.7 хувь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 9.7 хувь, бусад гэмт хэрэг 9.2 хувийг эзэлж байна.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн тоо 2011 онд 6462 болж, 2010 оныхоос 351 хэрэг буюу 5.2 хувиар буурсан хэдий ч энэ төрлийн хэргийн 90.3 хувийг эзэлж буй бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 5838 болж, 2010 оныхоос 17 хэрэг буюу 0.3 хувиар өссөн байна.

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн тоо 2011 онд 434 болж, 2010 оныхоос 24 хэрэг буюу 5.9 хувиар өссөний дотор энэ төрлийн хэргийн 84.6 хувийг эзэлж байгаа хүчингийн хэрэг 2010 оныхоос 7.3 хувиар өсчээ.

Өмчлөх эрхийн эсрэг 7232 гэмт хэрэг 2011 онд бүртгэгдэж, 2010 оныхоос 712 хэрэг буюу 9.0 хувиар буурахад энэ төрлийн гэмт хэргийн 73.0 хувийг эзэлж буй хулгайн хэрэг 501-ээр буурсан нь голлон нөлөөлжээ. Малын хулгайн гэмт хэргийн тоо 2011 онд 1169-д хүрч, 2010 оныхоос 99 хэрэг буюу 9.3 хувиар өссөн байна.

Булаах гэмт хэрэг 2011 онд 137 бүртгэгдэж, 2010 оныхоос 6 хэрэг буюу 4.2 хувиар, залилангийн гэмт хэрэг 688 болж, 2010 оныхоос 76 хэрэг буюу 9.9 хувиар буурсан бол 536 дээрмийн гэмт хэрэг бүртгэгдэж, 2010 оныхоос 16 хэрэг 3.1 хувиар их байна.

Танхайн гэмт хэрэг 2011 онд 1824 бүртгэгдсэн нь нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 97.4 хувийг эзэлж, 2010 оныхоос энэ төрлийн хэргийн тоо Сүхбаатар аймагт 66.7 хувь, Хэнтий аймагт 45.0 хувь, Булган аймагт 37.5 хувь, Орхон аймагт 33.3 хувь, Төв аймагт 14.8 хувь, Говь-Алтай аймагт 4.8 хувь, Улаанбаатар хотод 29.4 хувиар нэмэгджээ.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2011 онд 1870-д хүрч, 2010 оныхоос 231 хэрэг буюу 14.1 хувиар, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 270-д хүрснээр, 2010 оныхоос 39 хэрэг буюу 16.9 хувиар нэмэгдэв.

18 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд 2011 онд улсын дунджаар 103 гэмт хэрэг ногдож байгаа нь 2010 оныхоос 6 хэрэг буюу 5.5 хувиар буурсан ч Хэнтий (161), Дорноговь (137), Говьсүмбэр (123), Төв (113), Улаанбаатар (132)-т улсын дунджаас дээгүүр байна.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч 2011 онд 17982 байгаагийн 1163 буюу 6.5 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 2303 буюу 12.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэргийн улмаас 2011 онд 922 хүн нас барсны 237 буюу 25.7 хувь нь хүнийг санаатай алах гэмт хэргийн улмаас, 363 буюу 39.4 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас нас баржээ.

Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2011 онд 8210 болж, үүний 724 буюу 8.8 хувь нь эмэгтэйчүүд, 542 буюу 6.6 хувь нь хүүхдүүд (хүүхдүүдийн 26 буюу 4.8 хувь нь эмэгтэй хүүхэд) байна.

Товч танилцуулга |

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2011 онд 35.9 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын нийт хэмжээ 18.5 тэрбум төг болж, 2010 оныхоос учирсан хохирлын хэмжээ 7.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын нийт хэмжээ 28.9 хувиар өсөв. Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 70.8 хувь буюу 25.4 тэрбум төг нь хувийн өмчид ногдож байна.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 10829.7 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4881.4 тэрбум төг болж, 2010 оныхоос оны үнээр 2415.2 тэрбум төг буюу 28.7 хувиар, зэрэгцүүлэх үнээр 718.6 тэрбум төг буюу 17.3 хувиар өслөө.

ДНБ-ийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон 2011 оны 17.3 хувийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 164.6 тэрбум төг буюу 42.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 39.7 тэрбум төг буюу 16.0 хувь, уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт 64.1 тэрбум төг буюу 8.7 хувийн өсөлт голлон нөлөөллөө. Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2011 онд оны үнээр өмнөх оныхоос 55.7 хувиар, импорт 2010 оныхоос 2.0 дахин нэмэгдсэн нь уг салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн болно. Нэмэгдсэн өртгийн албан татвар оны үнээр 2011 онд 2010 оныхоос 529.2 тэрбум төг буюу 91.4 хувь, онцгой албан татвар 25.4 тэрбум төг буюу 9.5 хувь, гадаад худалдааны татварын орлого 144.1 тэрбум төг буюу 74.5 хувиар өссөн нь бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ оны үнээр 65.6 хувь нэмэгдэхэд нөлөөллөө.

Нэг хүнд ногдох ДНБ 2011 онд оны үнээр 3886.7 мян.төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1751.9 мян. төгрөгт, Үндэсний нийт орлого (ҮНО) оны үнээр 3557.3 мян.төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1603.4 мян. төгрөгт хүрлээ. Дэлхийн банкны атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох ДНБ 2011 онд оны үнээр 2562 ам.доллар, ҮНО 2345 ам.долларт хүрч байна.

Хувийн хэвшлийн нэмэгдэл өртөг 2011 онд ДНБ-ий 75.3 хувийг эзэлж, өмнөх оныхоос 1.9 пунктээр нэмэгдлээ.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2011 онд оны үнээр 10899.9 тэрбум төг болж, 2010 оныхоос 2440.3 тэрбум төг буюу 28.8 хувиар өссөн нь нийт хуримтлалын хэмжээ нэмэгдснээс голлон хамаарчээ. ДНБ-д эцсийн хэрэглээ 64.4 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 58.1 хувь, цэвэр экспорт -22.5 хувь болж, 2010 оныхоос эцсийн хэрэглээ 2.6 пункт, цэвэр экспорт 14.9 пунктээр буурч, харин хөрөнгийн нийт хуримтлал 17.5 пунктээр өссөн байна. Хөрөнгийн нийт хуримтлал 2011 онд 2010 оныхоос 2899.6 тэрбум төг буюу 84.5 хувь, экспортын хэмжээ 2271.0 тэрбум төг буюу 49.3 хувиар тус тус нэмэгдсэн нь ДНБ-ий бүтцэд гарсан үндсэн өөрчлөлт байлаа.

Орлогын аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 10829.7 тэрбум төг болж, 2010 оныхоос 28.7 хувиар өслөө. Орлогын аргаарх ДНБ-ий бүтцэд цалин, түүнтэй адилтгах орлого 23.9 хувь, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар 21.5 хувь, үйл ажиллагааны нийт ашиг, холимог орлого 54.5 хувийг эзэлж, 2010 оныхоос үйлдвэрлэл, импортын цэвэр татвар 0.5 пунктээр, үйл ажиллагааны нийт ашиг, холимог орлого 0.8 пунктээр нэмэгдэж, цалин, түүнтэй адилтгах орлого 1.3 пунктээр буурсан байна.

Улирлын ДНБ 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2011 оны 1 дүгээр улиралд 2010 оны мөн үеийнхээс 9.8 хувь, эхний хагас жилд 14.0 хувь, эхний 3 улиралд 16.5 хувь, харин жилийн дүнгээр 17.3 хувиар тус тус өслөө.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС

Үндэсний Статистикийн Хороо нь 2006 оноос нийслэл, аймгийн өрхийн хэрэглээний зардлын жингээр /жигнэсэн/ хэрэглээний үнийн улсын индексийг тооцож нийтэд мэдээлж байна.

Хэрэглээний үнийн улсын индекс 2010 оны жилийн эцэст өмнөх оныхоос 13.0 хувиар өссөн бол 2011 оны жилийн эцэст өмнөх оныхоос 10.2 хувиар өсч, өсөлтийн хурдац 2.8 пунктээр саарлаа.

Хэрэглээний үнийн улсын индекс 2011 оны эцэст өмнөх оны эцсийнхээс 10.2 хувь өсөхөд тээврийн

бүлгийн үнэ 16.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 14.1 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 13.9 хувь, боловсролын үйлчилгээнийх 11.9 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 11.2 хувь өссөн нь хамгийн өндөр байгаа бөгөөд гэр ахуйн бараа, тавилгынх 8.9 хувь, хүнсний бараа, ундаа усных 8.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 7.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрных 7.0 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 3.5 хувь, согтууруулах ундаа, тамхиных 3.3 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийнх 0.3 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн улсын индексийн 2011 оны өсөлтийн 3.6 нэгж нь хүнсний барааны бүлгийн үнийн өсөлтөөс; 1.9 нэгж нь хувцас, гутал, бөс барааны бүлгийн; 1.5 нэгж нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн; 1.4 нэгж нь тээврийн бүлгийн; 0.8 нэгж нь боловсролын бүлгийн; 0.5 нэгж нь гэр ахуйн бараа, тавилгын бүлгийн; 0.7 нэгж нь бусад бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Инфляцийн жилийн дундаж түвшин 2011 онд 9.2 хувь болж, 2010 оныхоос 0.9 пунктээр буурчээ.

Хэрэглээний үнийн сарын индекс улсын дүнгээр 2011 оны эхний 2 сард өмнөх сартай нь харьцуулахад 0.5-3.0 хувиар өсч байснаа 3-4 дүгээр сард 0.2-0.8 хувиар буурсан. Түүнчлэн 2011 оны 8 дугаар сард энэ үзүүлэлт 0.3 хувиар буурч, сүүлийн 4 сард 0.6-2.0 хувиар өссөн байна. Хэрэглээний үнийн индекс 2010 оны 1 дүгээр сард хамгийн өндөр (3.0%) өсч, харин 3 дугаар сард хамгийн их (-0.8%) буурсан байна.

Аймгуудад хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2011 оны эцэст өмнөх оныхтой харьцуулахад 5.3-14.2 хувиар өссөний дотор Дорнод аймагт 14.2 хувь нэмэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болсон бөгөөд Улаанбаатар хотод энэ үзүүлэлт 11.1 хувь байв.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүрийн 4-нд сум, дүүрэг, аймаг, нийслэлийн үнэ цуглуулдаг нэгжүүдээр гарган жилийн эцэст жилийн дундаж үнийг арифметик дундажаар тодорхойлж байна.

Манай улсын эдийн засгийн гол салбар болох хөдөө аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2011 онд улсын жилийн дундаж үнэ хонины ноостой нэхий 10.3 мян.төг болж, 2010 оныхоос 2.9 мян.төг буюу 39.2 хувь, үхрийн 2 метрээс дээш урттай шир 23.1 мян.төг болж, 2010 оныхоос 4.7 мян.төг буюу 25.5 хувь, адууны шир 25.6 мян.төг болж, 2010 оныхоос 3.9 мян.төг буюу 18.0 хувь, ямааны цагаан ноолуур 52.0 мян.төг болж, 2010 оныхоос 5.8 мян.төг буюу 12.6 хувиар өсч, харин ямааны ноолууртай арьс 15.5 мян.төг болж, 2010 оныхоос 2.9 мян.төг буюу 15.8 хувиар буурсан байна.

МӨНГӨ, ЗЭЭЛ

Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт (M2) 2011 оны жилийн эцэст 6412.3 тэрбум төг болж, 2010 оныхоос 1732.3 тэрбум төг буюу 37.0 хувиар өсөхөд бараг мөнгө 1148.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

Төгрөгийн хадгаламж 2011 оны эцэст 2912.4 тэрбум төг болж, 2010 оныхоос 910.8 тэрбум төг буюу 45.5 хувиар өсөхөд иргэдийн хадгаламж 751.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Гадаад валютын хадгаламж 2011 онд 2010 оныхоос 223.3 тэрбум төг буюу 29.6 хувиар нэмэгдэж 977.9 тэрбум төгрөгт хүрчээ.

Мөнгөний нийлүүлэлт (M2)-нд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувь 2011 оны эцэст 8.1 хувь болж, 2010 оныхтой харьцуулахад 0.2 пунктээр буурчээ.

Арилжааны банкуудын олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2011 оны эцэст 5641.2 тэрбум төг болж, 2010 оныхоос 2376.5 тэрбум төг буюу 72.8 хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь 2011 онд 5.8 хувь болж, 2010 оныхоос 5.7 пунктээр буурчээ.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2011 оны эцэст 2010 оныхоос 2.4 пунктээр буурч, жилийн хүү 15.5 хувь, валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 2010 оныхоос 0.5 пунктээр буурч, жилийн хүү 12.1 хувь болжээ.

Төгрөгийн америк доллартай харьцах жилийн дундаж ханш 1265.46 төг болж 2010 оныхтой харьцуулахад 6.7 хувь, евротой харьцах жилийн дундаж ханш 1761.27 төг болж 2.2 хувь, юаньтай харьцах жилийн дундаж

Товч танилцуулга |

ханш 195.91 төг болж 2.2 хувь, рубльтэй харьцах жилийн дундаж ханш 43.08 төг болж 3.6 хувиар чангарчээ.

Гадаад валютын цэвэр албан нөөц 2011 оны эцэст 2010 оныхоос 126.4 сая ам.долл буюу 6.0 хувиар нэмэгдэж 2217.6 сая ам.долларт хүрсэн нь манай улсын импортын 20.2 долоо хоног буюу 5.1 сарын хэрэгцээг хангахаар байна.

Үнэт цаасны зах зээл

Монголын хөрөнгийн биржид 2011 оны эцэст 332 компани бүртгэлтэй байгаагаас 52 нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани, 280 нь хувийн өмчийн компани байна.

Үнэт цаасны арилжаа 2011 онд нийт 252 өдөр явагдаж, 350.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийв. Хөрөнгийн зах зээл дээрх нийт үнэлгээний дүн 2168.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2010 оныхтой харьцуулахад 57.8 хувиар өсчээ.

ТОП-20 дундаж индекс 2010 онд 10582.8 байсан бол 2011 онд 21420.8 болж өссөн бөгөөд 2011 онд өдөрт дунджаар 487.2 мян.хувьцаа арилжаалагдаж, 433.0 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Ремикон, Гермес центр, Силикат, Бэрх уул, Женко түр бюро, Монгол шилтгээн зэрэг хувьцаат компаний хувьцаа хамгийн идэвхтэй арилжаалагдсаны зэрэгцээ Таван толгой, АПУ, Багануур, Шивээ овоо, Шарын гол, Бэрх уул зэрэг хувьцаат компани зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй компаниудын тоонд орж байна.

Санхүүгийн бусад салбар

Даатгал. Хүний ажил амьдралд учирч болзошгүй тааламжгүй үйл явдлын эрсдэлийг бууруулах, түүний хохирол, үр дагаврыг богино хугацаанд арилгах санхүүгийн үр дүнтэй арга хэрэгслийн нэг нь арилжааны даатгал юм. Манай улсад 2011 онд нийт 17 байгууллага даатгалын, 8 байгууллага даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулсан байна. Даатгалын байгууллагууд 2011 онд 47.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олж, 10.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлжээ. Хураамжийн орлого 2010 оныхоос 49.5 хувь, нөхөн төлбөр 15.2 хувиар өслөө.

Банк бус санхүүгийн байгууллага. Улсын хэмжээнд 2011 онд нийт 195 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж, 45.2 тэрбум төгрөгийн санхүүгийн орлого олж, 14.5 тэрбум төгрөгийг санхүүгийн зардалд зарцуулж, 28.6 тэрбум төгрөгийн санхүүгийн цэвэр ашигтай ажилласан байна. Санхүүгийн орлого 2010 оныхоос 55.9 хувь, санхүүгийн цэвэр ашиг 59.1 хувь, санхүүгийн зардал 65.0 хувиар өсчээ.

Хадгаламж, зээлийн хоршоо. Тусгай зөвшөөрөлтэй хадгаламж зээлийн 162 нэгж 2011 онд үйл ажиллагаа явуулж, 12.4 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олж, 7.4 тэрбум төгрөгийг хүүгийн төлбөрт зарцуулж, 5.0 тэрбум төгрөгийн хүүгийн цэвэр ашигтай ажилласан ба хүүгийн орлого 2010 оныхоос 10.8 хувь, хүүгийн зарлага 16.1 хувь, хүүгийн цэвэр ашиг 3.7 хувиар өсчээ.

УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4400.6 тэрбум төг болж, 2008 оныхоос 2230.3 тэрбум төг буюу 2.0 дахин, 2009 оныхоос 2406.6 тэрбум төг буюу 2.2 дахин, 2010 оныхоос 1278.2 тэрбум төг буюу 40.9 хувиар өсөв.

Татварын нийт орлого өмнөх оныхоос 948.6 тэрбум төг буюу 35.3 хувиар нэмэгдэхэд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 367.3 тэрбум төг буюу 86.8 хувиар буурсан хэдий ч дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 563.2 тэрбум төг буюу 65.1 хувь, бусад татварын орлого 262.2 тэрбум төг буюу 84.7 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 154.4 тэрбум төг буюу 39.5 хувь, гадаад худалдааны татварын орлого 144.1 тэрбум төг буюу 74.5 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 119.1 тэрбум төг буюу 36.0 хувь, хүн амын орлогын албан татварын орлого 69.7 тэрбум төг буюу 43.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оныхоос 114.4 тэрбум төг буюу 29.3 хувиар нэмэгдэхэд хувьцааны ногдол ашгийн орлого 33.4 тэрбум төг буюу 60.5 хувь, төсөвт газрын өөрийн орлого 22.1 тэрбум төг буюу 13.5

хувь, хүү, торгуулийн орлого 21.4 тэрбум төг буюу 59.2 хувь, газрын тосны орлого 21.2 тэрбум төг буюу 38.7 хувь, бусад нэр заагдаагүй орлого 12.8 тэрбум төг буюу 26.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Нийт орлого, тусламжийн дүнд урсгал орлого 2008 онд 99.1 хувь, 2009 онд 98.9 хувь, 2010 онд 98.6 хувь, 2011 онд 94.1 хувийг эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4792.0 тэрбум төг болж, 2008 оныхоос 2325.3 тэрбум төг буюу 94.3 хувь, 2009 оныхоос 2455.4 тэрбум төг буюу 2.1 дахин нэмэгдсэн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оныхоос 1711.3 тэрбум төг буюу 55.6 хувиар нэмэгдсэн нь зээлийн үйлчилгээний төлбөр 5.0 тэрбум төг буюу 11.8 хувиар буурсан хэдий ч татаас, шилжүүлгийн зардал 621.4 тэрбум төг буюу 59.3 хувь, хөрөнгийн зардал 476.1 тэрбум төг буюу 80.6 хувь, бараа, үйлчилгээний зардал 361.8 тэрбум төг буюу 31.0 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 257.1 тэрбум төг буюу 2.1 дахин өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зарлага 2008 онд 71.4 хувь, 2009 онд 76.5 хувь, 2010 онд 73.2 хувь, 2011 онд 67.5 хувийг эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүний 40.6 хувийг эзэлж, 2008 оныхоос 7.5, 2009 оныхоос 10.3, 2010 оныхоос 3.5 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүний 44.2 хувийг эзэлж, 2008 оныхоос 6.6, 2009 оныхоос 8.7, 2010 оныхоос 7.6 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Улсын нэгдсэн төсөв 2010 онд 41.8 тэрбум төгрөгийн ашигтай гарч, дотоодын нийт бүтээгдэхүүний 0.5 хувийг эзэлж байсан бол 2008, 2009, 2011 онд алдагдалтай гарчээ. Дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн алдагдал 2008 онд 4.5, 2009 онд 5.2 хувь байв. 2011 онд улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 3.6 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарлаа.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөрөнгийн зардлын эзлэх хувь 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9.9 хувь болж, 2008 оныхоос 0.4, 2009 болон 2010 оныхоос тус бүр 2.9 пунктээр нэмэгджээ.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцэл 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 33.7 сая ам.долларын ашигтай гарч, ашгийн хэмжээ өмнөх оныхоос 839.4 сая ам.долл буюу 25.9 дахин буурлаа. Урсгал тэнцэл 2568.3 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал 1681.6 сая ам.долл буюу 2.9 дахин өслөө. Барааны тэнцэл 925.1 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оныхоос 744.7 сая ам.долл буюу 5.1 дахин, үйлчилгээнийх 1158.3 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оныхоос 863.8 сая ам.долл буюу 3.9 дахин өссөн нь нийт урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэхэд нөлөөлжээ.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж 90.3 сая ам.долларын ногдол ашиг төлснөөр орлогын дансны алдагдал 725.3 сая ам.долл болж, өмнөх оныхоос алдагдал 126.5 сая ам.долл буюу 21.1 хувиар өссөн байна.

Хөрөнгө ба санхүүгийн дансны тэнцлийн ашиг 2.3 тэрбум ам.долл болж, өмнөх оныхоос ашиг 556.3 сая ам.долл буюу 31.9 хувиар өсөхөд шууд хөрөнгө оруулалт өмнөх оныхоос 2.1 тэрбум ам.долл буюу 2.3 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ИХ БАРИЛГА

Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 2011 онд 6545.8 тэрбум төг болж, өмнөх оныхоос 2700.0 тэрбум төг буюу 70.2 хувиар өслөө.

2011 онд хөрөнгө оруулалтын 30.0 хувь нь дотоод эх үүсвэрээр, 70.0 хувь нь гадаад эх үүсвэрээр санхүүжигдсэн бөгөөд өмнөх оныхоос дотоод эх үүсвэрийн хөрөнгө оруулалт 558.5 тэрбум төг, гадаад эх

Товч танилцуулга |

үүсвэрийн хөрөнгө оруулалт 2141.5 тэрбум төгрөгөөр өсчээ.

Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхэд гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оныхоос 2041.8 тэрбум төгрөгөөр, зээл, тусламж нь 99.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

2011 онд нийт хөрөнгө оруулалтын 15.5 хувийг эзэлж буй улсын төсвийн хөрөнгө оруулалт 1015.7 тэрбум төг болж, өмнөх оныхоос 454.1 тэрбум төг буюу 80.9 хувиар өссөн бөгөөд хувийн жин нь 0.9 пунктээр нэмэгдэв. Нийт хөрөнгө оруулалтад дотоод эх үүсвэрийн хөрөнгө оруулалтын хувийн жин буурсан нь түүний хэмжээ буурснаас бус гадаад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтын хурдац өндөр байгаагаас шалтгаалжээ.

Нийт хөрөнгө оруулалтын 11.4 хувь нь барилга угсралт, их засварын ажилд, 65.1 хувь нь машин, тоног төхөөрөмжийн худалдан авалтанд ногдож байна. Өмнөх оныхоос барилга угсралт, их засварын ажилд оруулсан хөрөнгө оруулалт 0.6 пунктээр буурч, машин, тоног төхөөрөмжийн худалдан авалт 18.2 пунктээр нэмэгджээ. Үүнд, уул уурхайд чиглэсэн машин, тоног төхөөрөмжийн импорт голлон нөлөөлж байна.

ИХ БАРИЛГА

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2011 онд 745.0 тэрбум төгрөгт хүрсний 88.2 хувь буюу 657.2 тэрбум төгрөгийн ажлыг дотоодын, 87.8 тэрбум төгрөг буюу 11.8 хувийн ажлыг гадаадын барилгын байгууллагууд гүйцэтгэв.

Улсын хэмжээнд 2011 онд нийтдээ 686.0 тэрбум төгрөгийн орон сууц, үйлдвэр, үйлчилгээний барилга объектыг ашиглалтад оруулсан нь өмнөх оныхоос 85.5 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар өслөө.

2011 онд 11349 айлын орон сууцны 159 барилга; эрчим хүчний 113; албан тасалгааны зориулалтаар 86; сургууль, соёлын 65; далан, суваг, шугам сүлжээ, худалдаа, үйлчилгээний зориулалтын тус бүр 62, үйлдвэрлэлийн зориулалтаар 11, зочид буудлын 9, нийтдээ 794 барилга, байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Дотоодын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын 72.1 хувь нь Улаанбаатар хотод, 4.9 хувь нь Ховд, 3.1 хувь нь Орхон, 2.9 хувь нь Увс аймагт тус тус ногдож байна. Сүүлийн 4 жилийн дунджаар барилга угсралт, их засварын ажил Булган, Дорноговь, Увс, Ховд, Хөвсгөл аймагт 33.8-79.6 хувиар өссөн байхад Баянхонгор, Өвөрхангай, Орхон аймагт 1.3-10.3 хувиар буурчээ.

Дотоодод үйлдвэрлэсэн вакуум цонх, эмульс, хөөсөндөр, замаскнаас бусад барилгын гол нэрийн материалын үнэ 2011 онд өслөө. 2011 онд нэг ширхэг улаан тоосгоны дундаж үнэ 148.4 төг болж өмнөх оны дунджаас 5.9 төг буюу 4.2 хувь, нэг шоо метр ховилгүй шалны банзных 146.8 мян.төг болж 13.9 мян. төг буюу 10.5 хувь, 50 кг-ийн савлагаатай цементнийх 6.9 мян.төг болж 1.1 мян.төг буюу 19.4 хувь, нэг шоо метр хөнгөн бетоных 106.7 мян.төг болж 18.1 мян.төг буюу 20.4 хувь, нэг шоо метр захалсан банзных 37.7 мян.төг болж 11.2 мян.төг буюу 42.1 хувь, хуурай палкных 25.4 мян.төг болж 9.3 мян.төг буюу 57.2 хувиар тус тус өсчээ.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал аж ахуй

Манай улсын эдийн засгийн гол салбар бэлчээрийн мал аж ахуй нь улс орны эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлогод чухал байр суурь эзэлсэн хэвээр байна. Хөдөө аж ахуйн салбар 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий 13.0 хувийг үйлдвэрлэж байгаа бөгөөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн 79.2 хувийг мал аж ахуйн салбар эзэлж байна. Хөдөө аж ахуйн салбарт 2011 оны байдлаар улсын хэмжээнд нийт ажиллагчдын 33.0 хувь, экспортын орлогын 6.5 хувь нь ногдож байна.

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 1505.3 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 779.0 тэрбум төгрөгт хүрч, 2010 оныхоос оны үнээр 16.6 хувиар өсч, харин зэрэгцүүлэх үнээр 0.01 хувиар буурлаа.

Мал аж ахуйн салбарт 2011 онд нядалгааны жингээр 208.0 мян.т мах, 458.6 мян.т сүү, 53.6 сая ш өндөг, 17.6 мян.т хонины ноос, 4.4 мян.т ноолуур, 8.8 сая ширхэг арьс, шир бэлтгэв.

Улсын хэмжээнд 2011 онд 2010 оныхоос ноолуурын үйлдвэрлэл 1.8 мян.т, хонины ноосны үйлдвэрлэл 5.8 мян.т, арьс, ширний үйлдвэрлэл 8.0 сая ширхэгээр буурч, махны үйлдвэрлэл, нядалгааны жингээр 6.8 мян.т, сүүний үйлдвэрлэл 120.2 мян.тонноор өссөн байна.

Хувийн малтай өрхийн тоо 2011 онд нийт өрхийн 27.9 хувь буюу 211.7 мянга байгаагийн 154.9 мянга нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 311.2 мян.малчид ажиллаж байна.

Малын 2011 оны тооллогын дүнгээс үзэхэд нийт малчин өрхийн 87.8 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 80.7 хувь нь телевизортой, 31.3 хувь нь автомашинтай, 48.3 хувь нь мотоцикльтой, 1.8 хувь нь трактортой, 78.1 хувь нь малын хашаатай, 21.4 хувь нь худагтай байна.

2011 оны байдлаар оны эхэнд тоологдсон эх малын 84.6 хувь буюу 13.1 сая эх мал төллөж, гарсан төлийн 94.9 хувь буюу 12.5 сая төл бойжууллаа.

Малын тоо 2011 оны эцэст 36.3 сая толгойд хүрч, 2010 оныхоос 3.6 сая.толгой буюу 11.0 хувиар өслөө. Үүний дотор адуу 2112.9 мян, үхэр 2339.7 мян, тэмээ 280.1 мян, хонь 15.7 сая, ямаа 15.9 саяд хүрч, 2010 оныхоос адуу 192.6 мян, үхэр 163.7 мян, тэмээ 10.5 мян, хонь 1.2 сая, ямаа 2.1 сая толгойгоор өссөн байна. Малын тоо 2011 онд 2010 оныхоос 14 аймагт 5 төрөл дээрээ өсчээ. Өвөрхангай (415.1 мян), Архангай (305.1 мян), Говь-Алтай (297.8 мян), Завхан (288.4 мян), Баянхонгор (274.8 мян) аймгуудад малын тоо хамгийн их хэмжээгээр өсчээ.

Оны эхэнд тоологдсон нийт малын 2.0 хувь буюу 0.7 сая том мал 2011 онд зүй бусаар хорогдов.

Улсын хэмжээгээр 2011 онд тэжээлийн нэгжид шилжүүлснээр 663.2 мян.т тэжээл үйлдвэрлэсэн бөгөөд хонин толгойд шилжүүлснээр нэг малд 11.0 кг тэжээл ногдож байгаа нь 2010 оныхоос 0.3 кг-аар доогуур байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээгээр 2011 онд сүүний чиглэлийн үнээний 901, махны чиглэлийн үхрийн 64, мах, ноосны хонины 200, гахайн 187, тахианы 217, зөгийн 81 эрчимжсэн аж ахуй (ферм) үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2010 оныхоос 366-гаар нэмэгдсэн байна.

Газар тариалан

"Атрын III аян"-ы өмнөх таван жил /2003-2007/-ийн дундажтай зэрэгцүүлэхэд 2011 онд хураасан үр тариа 323.9 мян.т буюу 3.7 дахин, төмс 109.9 мян.т буюу 2.2 дахин, хүнсний ногоо 36.1 мян.т буюу 57.4 хувиар өссөн байна.

Улсын хэмжээгээр 2011 оны байдлаар нийт 345.9 мян.га талбайд тариалалт хийснээс 299.9 мян.га-д үр тариа, 15.4 мян.га-д төмс, 7.8 мян.га-д хүнсний ногоо, 10.9 мян.га-д тэжээлийн ургамал, 11.9 мян.га-д техникийн ургамал, жимс, жимсгэнэ тариалсан нь 2010 оныхоос нийт тариалсан талбай 30.6 мян.га-гаар буюу 9.7 хувь өссөн байна. Улсын хэмжээнд 2011 онд 446.1 мян.т үр тариа, 201.6 мян.т төмс, 99.0 мян.т хүнсний ногоо, 40.4 мян.т тэжээлийн ургамал хурааж, 1195.2 мян.т өвс хадлан, 46.7 мян.т гар тэжээл бэлтгэсэн нь 2010 оныхоос үр тариа 91.0 мян.т буюу 25.6 хувь, төмс 33.6 мян.т буюу 20.0 хувь, хүнсний ногоо 16.7 мян.т буюу 20.3 хувь, тэжээлийн ургамал 5.6 мян.т буюу 16.1 хувь, бэлтгэсэн өвс хадлан 57.9 мян.т буюу 5.1 хувь, гар тэжээл 14.0 мян.т буюу 42.8 хувиар өслөө.

Нэг га-гаас 14.9 цн үр тариа, 131.1 цн төмс хураасан нь 2010 оныхоос үр тарианых 1.2 цн, төмснийх 9.5 центнерээр их байна.

2011 онд эх орны үр тарианы хэрэгцээний 98.3 хувийг, төмсний 97.2 хувийг, хүнсний ногооны 55.3 хувийг дотоодын ургацаар хангах нөхцөл бүрдлээ.

АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр 2011 онд 6185.6 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2126.3 тэрбум төг боллоо. Зэрэгцүүлэх үнээр тооцсон үйлдвэрлэлийн хэмжээ 2008 оныхоос 302.9 тэрбум төг буюу 16.6 хувь, 2009 оныхоос 363.0 тэрбум төг буюу 20.6 хувь, 2010 оныхоос 187.5 тэрбум төг буюу 9.7 хувиар өслөө.

Энэхүү өсөлтөд газрын тос, нүүрс зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 16.8-22.6 хувь, төмрийн хүдэр 77.3 хувь, нарийн боов, сүлжмэл эдлэл, самнасан ноолуур, малын мах, талх, амтат ус, ундаа, шингэн сүү, тамхи, архи, жүүс, шар айраг, цэвэр ус,

Товч танилцуулга |

тэмээний ноосон хөнжил зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.8-68.6 хувь, бетон зуурмаг 86.5 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2011 онд 5626.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулж, 2010 оныхоос 1158.5 тэрбум төг буюу 25.9 хувиар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн нийт борлуулалтад боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2011 онд 27.8 хувь болж, 2010 оныхоос 6.8 пунктээр өсч, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 64.9 хувь болж, 2010 оныхоос 5.7 пункт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 7.3 хувь болж 1.1 пунктээр буурчээ.

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж оны үнээр 2011 онд 113.4 сая төг болж, 2010 оныхоос 16.5 сая төг буюу 17.0 хувиар өссөн байна. Хөдөлмөрийн бүтээмж оны үнээр 2010 оныхоос уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 26.2 сая төг буюу 13.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 15.8 сая төг буюу 23.3 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 2.6 сая төг буюу 8.7 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийг ажиллагчдын тооны бүтцээр авч үзвэл нийт үйлдвэрлэлийн 21.4 хувийг 1-99 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 78.6 хувийг 100-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэсэн байна.

ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2011 онд 44.1 сая т ачаа, давхардсан тоогоор 296.2 сая хүн тээвэрлэж, ачаа эргэлт 16336.7 сая т.км, зорчигч эргэлт 4695.7 сая хүн км-т хүрсэн байна. Үүнээс авто тээврээр 25.6 сая т ачаа, давхардсан тоогоор 291.8 сая хүн, төмөр замын тээврээр 18.4 сая т ачаа, давхардсан тоогоор 3.8 сая хүн, агаарын тээврээр 2.9 мян.т ачаа, давхардсан тоогоор 0.6 сая хүн тээвэрлэв.

Тээсэн ачаа 2011 онд 2010 оныхоос 14.7 сая т буюу 49.9 хувь, зорчигчдын тоо 45.5 сая зорчигч буюу 18.2 хувиар өслөө. Авто тээврээр тээсэн ачаа 2010 оныхоос 2.0 дахин, ачаа эргэлт 2.7 дахин өсөхөд Өмнөговь аймгийн нутагт олборлож буй нүүрсний хэмжээ ихэссэн нь голлон нөлөөлсөн.

Техникийн хяналтын үзлэгээр 2011 онд бүх төрлийн авто машин нийтдээ 312.5 мянгад хүрсний 208.5 мянга нь суудлын, 75.1 мянга нь ачааны автомашин, 22.5 мянга нь автобус, 6.4 мянга нь тусгай зориулалтын тоноглол бүхий тээврийн хэрэгсэл байна. Нийт автомашины 67.1 хувь буюу 209.8 мянга нь Улаанбаатарт ногдож байна. Нийт авто машины 18.2 хувь нь 9 жил хүртэл, 81.8 хувь нь 10 ба түүнээс дээш жил ашигласан байна.

Манай улсын авто тээврийн сайжруулсан замын нийт урт 2011 оны эцэст 7633.4 км, үүнээс хатуу хучилттай зам 4063.4 км болжээ. Нийт сайжруулсан замын урт 2011 онд 2010 оныхоос 899.0 км, үүний дотор хатуу хучилттай замын урт 1047.8 км-ээр нэмэгджээ.

ХАРИЛЦАА ХОЛБОО

Сүүлийн жилүүдэд үүрэн утасны хэрэглэгчдийн тоо мэдэгдэхүйц нэмэгдэж, давхардсан тоогоор 2011 онд 2942.3 мянгад хүрсэн нь өмнөх оныхоос 409.4 мянга буюу 16.2 хувиар өсчээ. Түүнчлэн сансрын холбооны хэрэглэгчдийн тоо 2010 онд 773 байсан бол 2011 онд 986-д хүрсэн байна.

Суурин утасны цэгийн тоо 2011 онд 131.8 мянга болж, 2010 оныхоос 11.4 мянгаар буурлаа.

Кабелийн телевизийн сүлжээ анх 1996 онд байгуулагдсан бөгөөд 2011 оны байдлаар сүлжээнд 180.1 мянган хэрэглэгчид холбогдсон байна.

Интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо 2010 онд 77 байсан бол 2011 онд 85 болж нэмэгдсэн байна.

Шуудангийн үйлчилгээний салбар 2010 онд 744.0 мян.ш бичиг, захидал, илгээмжийг явуулж, 10.6 сая ш тогтмол хэвлэлийг хүргэж байсан бол 2011 онд 879.1 мян.ш бичиг, захидал, илгээмжийг явуулж, 13.5 сая ш тогтмол хэвлэлийг үйлчлүүлэгчдэд хүргэсэн нь 2010 оныхоос бичиг, захидал, илгээмжийн тоо 18.2 хувь, тогтмол хэвлэлийн шуудан үйлчилгээ 27.2 хувиар өсчээ.

Харилцаа холбооны үйлчилгээний орлого 2011 онд 459.0 тэрбум төгрөгт хүрч, 2010 оныхоос 57.4 тэрбум төг буюу 14.3 хувиар өсчээ. Нийт орлогын 74.9 хувийг хүн амаас орсон орлого эзэлж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2011 онд 1713 болж, тэдгээрийн 35.8 хувь нь компьютер програмчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа; 29.7 хувь эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа; 17.3 хувь нь цахилгаан холбоо; 8.1 хувь нь өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүд байна (Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын үр дүнгээр).

ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2011 онд 11415.9 сая ам.долл, үүнээс экспорт 4817.5 сая ам.долл, импорт 6598.4 сая ам.долларт хүрч, нийт бараа эргэлт 2010 оныхоос 5307.3 сая ам.долл буюу 86.9 хувь, экспорт 1909.0 сая ам.долл буюу 65.6 хувь, импорт 3398.3 сая ам.долл буюу 2.1 дахин өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 1780.9 сая ам.долларын алдагдалтай гарч, 2010 оныхоос 1489.3 сая ам.долл буюу 6.1 дахин өссөхөд импортын өсөлт экспортынхоос 40.6 пунктээр илүү байгаа нь нөлөөлөв.

Экспорт өмнөх оныхоос давсан өсөлтөд үнэт ба хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийн экспорт 2010 оныхоос 68.4 сая ам.долл, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүнийх 29.4 сая ам.доллараар буурсан хэдий ч эрдэс бүтээгдэхүүний экспорт 1944.9 сая ам.долл, нэхмэл бүтээгдэхүүнийх 25.1 сая ам.долл, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэлийнх 18.6 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

Импортын хэмжээ 2010 оныхоос 3398.3 сая ам.доллараар нэмэгдэхэд машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 1102.7 сая ам.долл, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн бүлгийн импорт 905.3 сая ам.долл, эрдэс бүтээгдэхүүний импорт 519.5 сая ам.долл, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүнийх 391.4 сая ам.долл, хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэлийнх 120.3 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 93.1 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв.

Монгол Улсын экспортод уул уурхайн бүтээгдэхүүн голлож, эрдэс бүтээгдэхүүний экспорт 2000 онд 35.2 хувь, 2005 онд 42.7 хувь, 2010 онд 81.0 хувь эзэлж байсан бол 2011 онд 89.2 хувь болж нэмэгдлээ.

Экспортын дүнд 2011 онд нүүрс 47.2 хувь, зэсийн баяжмал 20.1 хувь, төмрийн хүдэр 9.2 хувь, боловсруулаагүй газрын тос 5.3 хувь, цайрын хүдэр, баяжмал 3.0 хувь, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 2.3 хувь, самнасан ноолуур 1.2 хувь, оёмол болон сүлжмэл бүтээгдэхүүн 0.5 хувийг эзэлж, үлдсэн 11.2 хувь нь экспортын бусад бүтээгдэхүүнд ногдож байна.

Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспорт 2009 онд нийт экспортын дүнгийн 16.4 хувь, 2010 онд 6.1 хувийг эзэлж байсан бол 2011 онд 2.3 хувь болж буурсан бөгөөд харин нүүрсний экспорт 2009 онд нийт экспортын дүнгийн 16.2 хувь, 2010 онд 30.3 хувь, 2011 онд 47.2 хувь болж өссөн байна.

Хонь, хурганы боловсруулсан арьс буюу шевретийн 2011 онд экспортод гаргасан биет хэмжээ 2010 оныхоос 2.2 дахин, ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевроны экспортод гаргасан биет хэмжээ 14.0 хувиар өссөн байна. Харин бохир ноолуурын экспортолсон биет хэмжээ 8.8 хувь, самнасан ноолуурынх 45.0 хувиар буурчээ.

Нийт импортод 2011 онд 27.0 хувийг машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг, 22.9 хувийг авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, 19.3 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 9.0 хувийг үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүн, 5.0 хувийг хүнсний бэлэн бүтээгдэхүүн, 3.9 хувийг хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 3.5 хувийг хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл, үлдсэн 9.4 хувийг бусад бүлгийн бүтээгдэхүүн эзэлж байна

Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2011 онд 1026.5 мян.т буюу 1153.8 сая ам.долл болж, нийт импортын 17.5 хувийг эзэлж байна. Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2011 онд 2010 оныхоос 200.3 мян.т буюу 24.2 хувиар өслөө.

Монгол улс цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосны хэрэгцээг үндсэнд нь импортоор хангаж байна. Цагаан будааны 76.7 хувийг БНХАУ, 11.2 хувийг, 9.5 хувийг Вьетнам улсаас; элсэн чихрийн 47.1 хувийг Тайланд, 12.3 хувийг Колумба, 10.9 хувийг Бразил улсаас 2011 онд импортолсон байна. Харин ургамлын тосны 98.5 хувийг ОХУ-аас, гурилын 89.6 хувийг ОХУ, 9.6 хувийг Казахстанас импортолжээ.

Товч танилцуулга |

Суудлын автомашины импорт 2011 онд 2010 оныхоос 283.0 сая ам.долл буюу 2.7 дахин, ачааны машины импорт 373.9 сая ам.долл буюу 2.8 дахин, нийтийн тээврийн хэрэгслийн импорт 14.3 сая ам.долл буюу 2.1 дахин өссөнөөс тээврийн хэрэгсэл, суудлын болон ачааны машины сэлбэг, эд ангийн импортын хэмжээ өсчээ. Гадаад худалдааны нөхцлийн индекс 2011 онд 73.0 болж, 2010 оныхоос 38.9 пунктээр буурсан сөрөг үзүүлэлттэй байна.

ХУДАЛДАА, ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛНЫ ГАЗАР

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт оны үнээр 2011 онд урьдчилсан гүйцэтгэлээр 6793.6 тэрбум төг болж, 2010 оныхоос 1874.9 тэрбум төг буюу 38.1 хувиар өслөө. Худалдааны салбарын нийт үйлдвэрлэл 2011 онд 1800.3 тэрбум төг болж, 2010 оныхоос 286.3 тэрбум төг буюу 18.9 хувиар өсчээ. Бөөний худалдааны нийт үйлдвэрлэл 2011 онд 2010 оныхоос 135.9 тэрбум төг буюу 14.4 хувь, жижиглэн худалдааны 150.4 тэрбум төг буюу 26.4 хувиар өссөн байна. Худалдааны нийт үйлдвэрлэлийн 60.0 хувийг бөөний худалдаа, 40.0 хувийг жижиглэн худалдаа эзэлж байна.

Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр 48 болж, 2010 оныхоос 5 хүнээр буурсан нь худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй цэгийн тоо 2010 оныхоос 5345 буюу 10.2 хувиар нэмэгдсэнээс шалтгаалав.

Худалдааны нэг цэгт 2011 оны жилийн эцсийн байдлаар Баруун бүсэд 70, Хангайн бүсэд 65, Зүүн бүсэд 58, Төвийн бүсэд 47, Улаанбаатарт 39 хүн ногдож байна.

Зочид буудлын салбарын нийт үйлдвэрлэлт урьдчилсан байдлаар, оны үнээр 2011 онд 88.3 тэрбум төг болж, 2010 оныхоос 28.4 тэрбум төг буюу 47.4 хувиар өссөн байна. Уг салбарын ажиллагчдын тоо 2011 оны жилийн эцэст 6.0 мянга болж, 2010 оныхоос 824 хүнээр буюу 16.0 хувиар нэмэгдэв.

Нийтийн хоолны салбарын нийт үйлдвэрлэлт урьдчилсан байдлаар, оны үнээр 2011 онд 106.8 тэрбум төг болж, өмнөх оныхоос 16.9 тэрбум төг буюу 18.8 хувиар өсчээ. Энэ салбарын нийт ажиллагчдын тоо 2011 оны жилийн эцэст 6.5 мянга болж, 2010 оныхоос 1907 хүн буюу 41.9 хувиар нэмэгдэв.

ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ

Улсын хэмжээгээр 2011 онд нийт 624.8 мян.м² талбай бүхий орон сууцыг ашиглалтад оруулснаар орон сууцны фонд 10062.3 мян.м² болж, 2008 оныхоос 18.6 хувь, 2009 оныхоос 12.9 хувь, 2010 оныхоос 5.4 хувиар өсчээ.

Ус түгээх цэгийн тоо 2011 онд 1368 болж, 2010 оныхоос 6.2 хувиар, зөөврийн ус хэрэглэдэг өрхийн тоо 433.2 мянгад хүрч, өмнөх оныхоос 3.9 хувиар нэмэгдсэн байна.

Хог устгалын цэгийн тоо 2011 онд 411 болж, 2010 оныхоос 8 цэгээр буюу 1.9 хувиар буурчээ.

Улсын хэмжээнд 2011 онд нийт 2881 хүний багтаамжтай 662 халуун усны цэг үйл ажиллагаа явуулж байсан бол 2011 онд 3057 хүний багтаамжтай 690 халуун усны цэг ажиллаж, багтаамж нь 6.1 хувиар, цэгийн тоо нь 4.2 хувиар өслөө.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол Улсын хилээр 2011 онд давхардсан тоогоор 4.3 сая зорчигч нэвтэрсэн нь 2010 оныхоос 658.7 мян.хүн буюу 17.9 хувиар өссөн байна. Улсын хилээр 2011 онд орсон 2.2 сая зорчигчийн 46.3 хувь нь Замын-Үүд, 16.1 хувь нь Буянт-Ухаа, 9.9 хувь нь Гашуунсухайт, 8.8 хувь нь Алтанбулаг, 6.7 хувь нь Шивээ хүрэн, үлдсэн 12.2 хувь нь бусад боомтоор нэвтэрчээ.

Монгол Улсын хилээр 2011 онд гадаадын 627.0 мян.зорчигч орж ирсэн нь 2010 оныхоос 69.5 мян.хүн буюу 12.5 хувиар өсчээ. Тэдний 95.8 хувь нь 30 хүртэл хоног, 2.1 хувь нь 90 хүртэл хоног, 2.1 хувь нь 90,

түүнээс дээш хоногоор ирсэн бөгөөд 69.0 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгаас, 24.1 хувь нь Европ тивд, 3.4 хувь нь Америк тивд, 3.5 хувь нь Ойрхи Дорнод, Өмнөд Ази, Африк тивүүдэд хамрагдаж байна.

Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 55.3 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын (БНХАУ), 16.7 хувийг Оросын Холбооны Улсын (ОХУ), 7.1 хувийг Бүгд Найрамдах Солонгос Улсын (БНСУ), 2.6 хувийг Америкийн Нэгдсэн Улсын (АНУ), 2.4 хувийг Япон улсын, 15.9 хувийг бусад орны иргэд эзэлж байна. Гадаадын нийт зорчигчдод БНХАУ-аас ирсэн зорчигчдийн эзлэх хувь 2011 онд 2010 оныхоос 3.3 пункт, АНУ-ынх 0.3 пунктээр өсч, харин ОХУ-ынх 5.8 пункт, БНСУ-ынх 0.5 пункт, Япон улсынх 0.2 пунктээр буурсан байна.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 73.4 хувь нь жуулчлалын зорилгоор ирсэн бөгөөд 26.6 хувь нь ажиллах, суралцах болон байнга оршин суухаар ирсэн байна. Жуулчлалын зорилгоор ирэгчдийн тоо 2011 онд 2010 оныхоос 0.9 хувиар өсч, энэ зорилгоор хилээр орсон гадаадын иргэдийн 44.2 хувь нь 2011 оны эхний хагас жилд, 55.8 хувь нь сүүлийн хагас жилд ногдож байна.

Тус улсын хилээр 2011 онд давхардсан тоогоор 2.1 сая зорчигч гарсаны 1548.2 мянга буюу 71.4 хувь нь Монгол Улсын иргэд бөгөөд тэдний 86.1 хувь нь хувийн ажлаар гадаадад зорчсон байна. Гадаадад зорчсон манай иргэдийн 74.8 хувь нь БНХАУ (1.1 сая хүн), ОХУ (198.3 мян.хүн) болон БНСУ (42.2 мян.хүн)-д явсан байна.

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулсан 1022 аж ахуйн нэгж, байгууллага 2011 оны эцсийн байдлаар бизнес регистрийн санд бүртгэгдсэн нь 2010 оныхоос 596-аар буюу 2.4 дахин өсчээ. Энэ салбарт 2011 оны жилийн эцсийн байдлаар 4.3 мянган хүн ажиллаж байсан нь 2010 оныхоос 2261 хүнээр буюу 2.1 дахин өсчээ.

БҮТЭЭМЖ

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт нийт бүтээмж 1262-1414 төг байгаа нь бусад салбарынхаас харьцангуй өндөр, улсын дунджаас 1.7-1.9 дахин их байна.

Үндсэн хүчин зүйлсийн бүтээмж 2011 онд оны үнээр улсын түвшинд 2266 төг болж, 2010 оныхоос 172 төгрөгөөр нэмэгдлээ. Оны үнээр үндсэн капиталын бүтээмж 2011 онд 17984 төг болж, эрчим хүчнийх 25447 төг, үндсэн түүхий эд, материалынх 2404 төгрөгт хүрэв.

Хөдөлмөрийн бүтээмж 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4536.4 мян.төгрөгт хүрч, 2010 оныхоос 17.3 хувь өсөв.

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН САН

2011 оны 4-р сард зохион байгуулсан ААНБТ-д 66.5 мянган аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж байсан бол 2011 оны эцэст энэ үзүүлэлт 67.4 мянгад хүрлээ.

Нийт бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 48.1 мян. буюу 71.3 хувь нь үйл ажиллагаа явуулж, эдгээрийн 80.7 хувийг 1-9 ажиллагчидтай, 9.1 хувийг 10-19 ажиллагчидтай, 6.8 хувийг 20-49 ажиллагчидтай, 3.5 хувийг 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна. Энэ нь манай улсад цөөн ажиллагчидтай жижиг аж ахуйн нэгж, байгууллагууд зонхилох болсныг харууллаа.

Үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоонд 1-9 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь 2011 онд 2010 оныхоос 4.4 пунктээр буурч, харин 10-19 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагынх 2.4, 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагынх 1.4, 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагынх 0.6 пунктээр тус тус нэмэгдэв.

Аж ахуйн нэгж, байгууллагыг дотор бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нэгжийн хувийн жин өндөр хэвээр байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог сүүлийн 4 жилийн дунджаар авч үзвэл төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарынх 2.4 хувиар буурч, харин боловсруулах үйлдвэрийн болон тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарынх 22.7 хувь, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааных 23.1 хувь, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааных 26.4 хувь, барилгынх 29.2 хувиар өсчээ.

Товч танилцуулга |

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог өмнөх оныхтой харьцуулахад бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагааны салбарынх 3.8 мянга буюу 19.5 хувиар буурч, харин үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааных 2.6 мянга буюу 2.0 дахин, барилгын салбарынх 1.4 мянга буюу 95.0 хувь, боловсруулах салбарынх 1.6 мянга буюу 61.0 хувь, нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээнийх 1.8 мянга буюу 60.5 хувиар өслөө.

ААНБ-ын 2011 оны тооллогын дүнгээр хоршооны тоо 1755, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 29.1 тэрбум төг, гишүүдийн тоо 41.2 мянгад хүрсэн байна. Хоршоог салбарын бүтцээр авч үзвэл нийт хоршооны 560 буюу 31.9 хувийг ХАА, ойн аж ахуй, загасны аж ахуй, ан агнуур, 353 буюу 20.1 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоцикл, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ, 251 буюу 14.3 хувийг боловсруулах үйлдвэр, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбар тус тус эзэлж байна.

БАЙГАЛЬ ОРЧИН

Монгол Улсын нутаг дэвсгэрийг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзэхэд 2011 онд нийт нутгийн 73.8 хувийг хөдөө аж ахуйн газар, 15.9 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 9.1 хувийг ойн сан бүхий газар, 0.4 хувийг усны сан бүхий газар, 0.4 хувийг хот, тосгон, бусад суурины газар, 0.3 хувийг зам, шугам, сүлжээний газар эзэлж байна.

Байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 2011 онд 15497.8 сая төгрөгт хүрч, 2010 оныхоос 3825.7 сая төг буюу 32.8 хувиар нэмэгдсэн бөгөөд үүнээс 5.7 хувийг газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд, 8.0 хувийг байгаль хамгаалах санд, 13.9 хувийг байгаль орчны төвлөрсөн арга хэмжээнд, 17.7 хувийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтад, 22.5 хувийг байгаль орчны алба, байгаль хамгаалагчдын үйл ажиллагаанд, 32.2 хувийг ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд тус тус зарцуулжээ.

Хохирол учирсан газрын талбай 2008 онд 12341.4 мян.га, 2009 онд 11167.6 мян.га, 2010 онд 7364.5 мян.га байсан бол 2011 онд 9233.1 мян.га болж, 2010 оныхоос 1868.6 мян.га буюу 25.4 хувиар өсчээ. 2011 онд хохирол учирсан газрын 8870.1 мян.га буюу 96.1 хувь нь бэлчээр ба бусад өвслөг газар, 293.1 мян.га буюу 3.2 хувь нь ойн сан бүхий газар, 52.9 мян.га буюу 0.6 хувь нь тариалангийн газар, 11.1 мян.га буюу 0.1 хувь нь ухагдаж эвдэрсэн газар, 5.7 мян.га буюу 0.1 хувь нь хот, суурины газар, 0.2 мян.га буюу 0.002 хувь нь усны сан бүхий газар байна.

Аюулт үзэгдэл, осол 2011 онд нийт 3548 удаа гарсны улмаас 213 хүн амь насаа алдаж, 165.5 мян.толгой мал хорогдон, 9.6 тэрбум төгрөгийн хохирол учирав.

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС (ХХИ)

Монгол Улсын хүний хөгжлийн индекс сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд жил дараалан тасралтгүй өссөөр байгаа хэдий ч олон улсын түвшинд дундаж үзүүлэлттэй орнуудын тоонд багтаж байна. Энэ нь нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ харьцангуй бага байгаатай холбоотой юм.

Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон их, дээд сургуульд суралцагчдын 6-22 насны хүн амд эзлэх хувь 2011 онд өмнөх оныхоос 1.7 пунктээр, нэг хүнд ногдох ДНБ худалдан авах чадварын паритетаар 767.7 доллараар өссөн нь 2011 онд хүний хөгжлийн индекс 0.013 пунктээр нэмэгдэж, 0.769-д хүрэхэд голлон нөлөөлжээ.

ХХИ нь хүний хөгжлийн ерөнхий түвшин, төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд түүний зэрэгцээ жендерийн тэгш байдлыг судлах зорилгоор ялгаатай хоёр индексийг ашиглаж байна. Үүний нэг нь жендерийн хөгжлийн индекс (ЖХИ) юм. Уг индексийн шалгуур үзүүлэлтүүд нь хүний хөгжлийн индексийг тооцох гурван үндсэн үзүүлэлттэй ижил бөгөөд ялгаа нь эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй харьцуулан судлах боломж олгодгоороо онцлогтой. Хоёр дахь индекс нь эмэгтэй хүний нийгэмд эзэлж буй байр суурийг эрэгтэй хүнтэй харьцуулан илэрхийлэх жендерийн эрх мэдлийн хэмжүүр (ЖЭМХ) юм.

Жендерийн хөгжлийн индексийг тооцоход ашиглагдах гурван үзүүлэлтийн зарим нь эрэгтэйчүүдийнх

эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Тухайлбал, 2011 онд нэг хүнд ногдох ДНБ худалдан авах чадварын паритетаар эрэгтэйчүүдийнх 5911.3 долл байхад эмэгтэйчүүдэд 4016.8 долл байна. Харин Монгол эмэгтэй хүний дундаж наслалт 2011 онд 73.76 жил байхад эрэгтэйчүүдийнх 64.68 жил, 6-22 насандаа сургуульд хамрагдаж буй эрэгтэйчүүдийн хувь 80.4 байхад эмэгтэйчүүдийнх 86.7 хувь байна.

Жендерийн эрх мэдлийн хэмжүүр 2011 онд 0.400 байгаа нь эдийн засаг, улс төрийн хүрээ болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгааг илэрхийлж байна.

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын зарим шалгуур үзүүлэлтийн 2011 оны байдлаар хэрэгжилтийг авч үзэхэд:

Зорилго 1. Ядуурал, өлсгөлөнг бууруулах

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны судалгааны дүнгээр ядуурлын хамрах хүрээ нийт хүн амын 29.8 хувь байна. Хот, суурин газруудад ядуурал харьцангуй доогуур байгаа бөгөөд хотод 26.6 хувь, харин хөдөөд 33.3 хувь байна. Ядуурлын түвшин 2011 онд өмнөх оныхтой харьцуулахад хотод 5.6 пункт, хөдөөд 14.5 пунктээр буурчээ.

Зорилго 2. Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 2008 онд 91.5 хувь, 2009 онд 94.3 хувь, 2010 онд 94.7 хувь байсан бол 2011 онд 94.8 хувь болж, өмнөх оныхоос 0.1 пунктээр нэмэгдэв.

Нэгдүгээр ангиас 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувийн жин 2008 онд 92.8 хувь, 2009 онд 89.9 хувь, 2010 онд 92.9 хувь байснаа 2011 онд 93.2 хувь болж, өмнөх оныхоос 0.3 пунктээр нэмэгджээ.

Зорилго 3. Жендерийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Боловсрол эзэмшиж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдийн тооны харьцаа бага боловсролын түвшинд ойролцоо, харин дунд, дээд боловсролын түвшинд эмэгтэйчүүд давамгайлж байна. Суралцагчдын нийт тоонд хүйсийн харьцаа 2011 оны байдлаар бага боловсролд 0.95, дунд боловсролд 1.06, дээд боловсролд 1.43 байна.

Хөдөө аж ахуйгаас бусад салбарт ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2011 онд 47.6 болж, өмнөх оныхоос 0.8 пунктээр буурав.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсрол эзэмших хандлагатай байгаа боловч удирдах болон шийдвэр гаргах түвшний албан тушаалд тэдгээрийн төлөөлөл бага хэвээр байна. Хэдийгээр 1992 оны сонгуулиар эмэгтэйчүүд УИХ-ын нийт гишүүдийн 3.9 хувь, 1996 оны сонгуулиар 9.2 хувь, 2000 оны сонгуулиар 11.8 хувийн төлөөлөлтэй болж өсөх хандлагатай байсан ч 2004 оны сонгуулиар 6.6 хувь, 2008 оны сонгуулиар 3.9 хувь болж буурлаа.

Зорилго 4. Хүүхдийн эндэгдлийг бууруулах

1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2011 онд 20 болж, өмнөх оныхоос 6-гаар, нялхсын эндэгдлийн түвшин 2011 онд өмнөх оныхоос 16 байгаа нь 4 тохиолдлоор буурсан байна.

Зорилго 5. Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах

100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 1993 онд 259 байсан нь сүүлийн 20 жилийн хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд 2011 онд 49 болж, өмнөх оныхоос 2-оор нэмэгджээ.

Зорилго 6. Бэлгийн замын халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирус /ХДХВ/, дархлалын олдмол хомсдол (ДОХ), сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тогтоосноор Номхон далайн баруун эргийн бүсийн 37 орноос Монгол Улс сүрьеэгийн өвчлөлийн өндөр зэрэглэлтэй 7 оронд багтдаг. 100 000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөл 2008 онд 160, 2009 онд 157, 2010 онд 154, 2011 онд 143 болж буурчээ.

Зорилго 7. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах

Манай улсад 2011 оны байдлаар нийт газар нутгийн 13.4 хувь буюу 20.9 сая га талбай бүхий газар улсын тусгай хамгаалалтад байгаа ба ойгоор бүрхэгдсэн талбай нийт нутгийн 7.7 хувийг эзэлж байна.

Зорилго 8. Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх

Үндэсний нийт орлогод хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь 2011 онд урьдчилсан гүйцэтгэлээр 1.3 хувь болж, өмнөх оныхоос 1.5 пунктээр буурчээ.

Холбооны салбарт шинэ технологи эрчимтэй нэвтрэн 1000 хүн тутамд ногдох суурин телефон цэгийн тоо 2011 онд 47, интернет байнгын хэрэглэгчдийн тоо 164, үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 1056 болсон байна.

Зорилго 9. Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх

Авлигатай тэмцэх газраас холбогдох хуулийн дагуу авлигын индексийг 2 жил тутамд тооцож байгаа бөгөөд авлигын индекс 2009 онд 0.64 байсан бол 2011 онд 0.63 болсон байна.

Харин улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 2011 онд 4.07 болж, өмнөх оныхтой ижил түвшинд байна.

POPULATION

The population of Mongolia reached 2811.6 thousand at the end of the year 2011, increased by 50.6 thousand or 1.7 percent compared with the previous year. Out of the total population, 48.5 percent are males and 51.5 percent are females. Sex ratio is 94 males per 100 females.

A high migration stream to the Ulaanbaatar city is becoming a cause of rapid growth of population in capital city. In 2011, population density was 274 persons per square kilometer in Ulaanbaatar, increased by 30 person (12.1 percent) from 2008, 19 person (7.5 percent) from 2009 and 9 person (3.4 percent) from 2010, respectively.

The 66.2 percent of the usual residents population in Mongolia or 1789.2 thousands live in urban areas as end of the year 2011 particularly more than half the population of Dornod, Dornogovi, Govisumber, Darkhan-Uul and Orkhon aimags were living in urban areas. Whereas in Arkhangai, Bulgan, Dundgovi, Zavkhan, Ovorkhangai, Selenge, Sukhbaatar, Ovorkhangai and Tov aimags over 70 percent of the total population were living in rural areas.

Total 759.9 thousand households were estimated which 63.6 percent of them live in urban areas and 36.4 percent were in rural areas and there were 3.7 persons per household in 2011.

Birth rate or births per 1000 population increased in 2006-2009 reached 25.7 in 2009, while it decreased to 23.1 in 2010 then reached to 25.1 in 2011 increased by 2.0 percentage points from the previous year. Total births have reached 69.9 thousands and increased by 9.8 percent from 2008, by 1.0 percent from 2009 and by 10.4 percent compared with year 2010. Sex ratio at births is about 104 boys per 100 girls. Total fertility rate was 2.6 in 2008, 2.8 in 2009 and 2.4 in 2010 and it increased to 2.6 in 2011.

Death rate has increasing trend from 2008 and it reached 6.9 in 2011, increased by 0.2 percentage points from previous year.

At the aimag level, deaths per 1000 population is higher in Arkhangai and Bayankhongor, Dundgovi, Zavkhan, Tov, Sukhbaatar aimags while lowest in Bayan-Olgii, Govi-Altai, Omnogovi, Selenge aimag and Ulaanbaatar city as end of the year 2011. Infant mortality rate increased in 2008-2010, while it reached 16.5 in 2011 and decreased by 3.7 percentage points from the previous year.

In 2010, life expectancy at birth at the national level was 68.32 years, increased by 0.27 years compared to the previous year. And in 2011, life expectancy of female was 73.76 years; life expectancy of male was 64.68 years.

Total 11.9 thousand couples registered their marriages, 3.2 thousand couples divorced and 2.1 thousand children were adopted. Marriage increased by 27.0 percent and divorces by 5.5 percent, while child adoption decreased by 15.8 percent compared to the previous year. Whereas, marriage per 1000 population was sharply decreased from 12.7- to 3.4 in 2010, it has reached 4.3 and increased by 0.9 percentage points in 2011. Divorces have gradually increasing since 2008, reached 1.2 in 2011 and increased by 0.1 percentage points from previous year.

SOME POPULATION AND SOCIAL INDICATORS

A number of orphan children reached 40.8 thousand in 2011, representing 1.4 percent of the total population. It shows decreases by 15.2 percent from 2008, by 11.4 percent from 2009 and by 4.8 percent compared to year 2010. Out of all orphan children, 4.3 thousand or 10.6 percent are double orphans or have lost both parents and 36.5 thousands or 89.4 percent are half orphans or have lost one parent. A number of double orphan children decreased by 14.2 percent from 2008, by 8.1 percent from 2009 and by 7.7 percent from 2010 in 2011. Whereas, number of half orphan children decreased by 15.4 percent from 2008, by 11.4 percent from 2009 and by 4.7 percent from the year 2010.

